

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС



**2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ
ТАЙЛАН**

Мөрөн
2023 он

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

- 1. БОДЛОГО ЗОРИЛТЫГ ХАНГАХ ТАЛААР**
- 2. ХЭЛТСЭЭС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БУСАД АЖЛУУД**
- 3. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 4. ЭД ХӨРӨНГӨ, ХУУЛИЙ ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 5. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 6. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 7. АРХИВ, АЛБАН БИЧИГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 8. СУРГАЛТ, СЕМИНАР БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР**
- 9. ДҮГНЭЛТ**

1. БОДЛОГО ЗОРИЛТЫГ ХАНГАХ ТАЛААР

Тус хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Б/424 тоот тушаалаар батлагдсан бүтэц орон тооны дагуу Төрийн захиргааны 38 үндсэн ажилтан, төрийн үйлчилгээний 5 үндсэн ажилтан, гэрээт 4 албан хаагч нийт 47 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс хэлтсийн дарга 1, хяналтын улсын байцаагч 1, иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 1, иргэний улсын бүртгэгч 30, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 1, хуулийн этгээдийн улсын бүртгэгч 1, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч 3, ахлах нягтлан бодогч 1, мэдээлэл технологийн ажилтан 1, бичиг хэргийн эрхлэгч, нярав 1, архивч 2, гэрээт ажилтан 4 тус тус ажиллаж байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Татварын ерөнхий хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн хүрээнд төрийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажилласан. Мөн Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хамаарах шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд албан хаагчдад сургалт зохион байгуулах, мэдээлэл өгөх, улсын бүртгэгч нарт холбогдох чиглэлийг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.

2023 оны 11 сарын 25-ны өдрийн байдлаар УБЕГ-ын даргын 62 тушаал, 19 чиглэл, 10 албан даалгавар ирснийг албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг ханган, тайланг хугацаанд нь хүргүүлэн, УБЕГ-с зохион байгуулсан 28 удаагийн цахим болон танхимын сургалтанд хэлтсийн албан хаагчдыг бүрэн хамруулж ажилласан.

Хэлтсийн 36 албан хаагчийн 2022 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд цахимаар хүлээн авч баталгаажуулах, цаасан хэлбэрээр хүлээн авах, бүртгэх хадгалах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, тайлант хугацаанд шинээр томилогдсон 5 нийт 41 албан хаагчийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан Баталгааны маягтыг УБЕГ-т хүргүүлэн, нууцын баталгааг гаргуулан ажилласан.

Хэлтсийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 29 арга хэмжээтэйгээр боловсруулан, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар батлуулан, 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 29 арга хэмжээг хяналтандаа авч хэрэгжилтийг 100% ханган ажиллаж байна. Мөн хэлтсийн барилгын их засварын ажлыг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмэлтээр тусгаж, хэрэгжилт 100% хангагдсан байна.

Тус хэлтсийн барилгын их засварын төсвийг шийдвэрлүүлэхээр Хууль зүйн сайд Х.Нямбаатарт албан бичиг хүргүүлснээр засварын төсөв болох 478.000.000 /дөрвөн зуун далан найман сая/ төгрөгийг шийдвэрлүүлэн ажиллалаа. Тус хэлтсийн барилгын их засварын ажлыг хийж гүйцэтгэх байгууллагын тендерийн үйл ажиллагаа Улсын бүртгэлийн ерөнхий газарт зарлагдан “Өгөөмөр Уул” ХХК шалгарч барилгын их засварын ажлыг 2023 оны 06 дугаар сарын 18-ны өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн хооронд гүйцэтгэж, тус хэлтэст хүлээлгэж өгсөн бөгөөд хэлтсийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа бүрэн хангагдаад байна.

Аймгийн хэмжээнд тоон гарын үсэг авах 90464 иргэнээс өнгөрсөн оны тайлант хугацаанд 24372 иргэнд буюу 27%-тай байсан бол 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар нийт 51488 иргэнд тоон гарын үсэг олгож тоон гарын үсэг олгох ажил 57%-тай явагдаж, гүйцэтгэлийн төлөвлөгөө 100 хувь хэрэгжсэн.

“Төрийн үйлчилгээний цэг - Хаанаас ч ойрхон” Хурдан цахим машины шинэчлэлт хийгдэж, тус хэлтэст байршуулсан киоск машинаас иргэд бүртгэлийн лавлагаа, тодорхойлолт тоон гарын үсэг авах болон 60 байгууллагын 600 гаруй үйлчилгээг авах боломж бүрдсэн.

Тус хэлтсийн 1-11 дүгээр сарын иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний талаар 1 удаагийн инфографик мэдээллийг үнэн зөв гарган тус, хэлтсийн цахим хуудас болон хэлтсийн ил тод байдлын самбар, олон нийтийн сүлжээнд байршуулан, хэлтсийн албан хаагчид 49 цахим хуудсанд 215 удаагийн давтамжтай түгээн ажиллаж байна.

Тайлант хугацаанд хэлтсийн хэмжээнд иргэдээс 122 өргөдөл, гомдол хүлээн авж 97.5% шийдвэрлэсэн бөгөөд 1,2,3 дугаар улирлын өргөдөл гомдлын мэдээг УБЕГ-т хугацаа хоцроолгүй үнэн зөв хүргүүлэн ажиллаж байна.

Тус хэлтэс нь “Хөвсгөлийн Хөгжил дэвшилд” төрийн бус байгууллагаар 2023 оны 11 дүгээр сард 44 албан хаагч, 51 иргэн, Цагдаагийн газар, ШШГГ, Шүүхийн байгууллага болон, орчны ажиглалт гэсэн 4 үндсэн төрлөөр хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, үнэлгээний тайланг хүлээн авлаа.

Үнэлгээгээр тус хэлтсийн давуу тал:

- Иргэдэд үйлчлэх цахим үйлчилгээг нэмэгдүүлж цаг завьг хэмнэсэн иргэдэд цахим машиныг ашиглах зааврыг байршуулсан
- Албан хаагчид ажилдаа идэвх санаачлагатай иргэдэд үйлчилгээ үзүүлэхдээ эерэг хандлагатай байсан
- Иргэд бүртгэлийн үйлчилгээ авахад бүрдүүлэх материалын хөтөч дэвтэр ойлгомжтой байсан.

Сул тал:

- Хэлтсийн албан хаагчдын ахлах нягтлан бодогч, мэдээлэл технологийн ажилтан нарын тоног төхөөрөмж шинэчлэх шаардлагатай

- Төрийн албан хаагчтай иргэд зүй бусаар харьцах, дайрч доромжлох, үйлдэл гаргахгүй байхаас сэргийлэн хууль эрх зүйн санамж байршуулах.
- Орон нутгийн албан хаагчдад томилолтын зардал төсөвт суугаагүй зэрэг болно.

Улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газрын эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 7 хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хийж хэрэгжүүлэн илтгэх хуудсыг хүргүүлсэн. Мөн 13 чиглэл зөвлөмжийг улсын бүртгэгч нарт тухай бүр танилцуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. 2023 онд хяналтын улсын ахлах байцаагчийн 1500 дугаар дүгнэлт болон нэгжийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үндэслэн мэдээллийн санд алдаатай бүртгэгдсэн нийт 120 бүртгэлд засвар өөрчлөлт оруулсан байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн “Мэдээллийн сан цэгцлэх тухай” иргэний улсын бүртгэлийн санд нөхөн шивэлтээр бүртгэсэн төлөвтэй болон хоёр удаа нөхөн шивэлтээр бүртгэсэн 22 иргэний мэдээллийг шалгаж дараах ажлыг хийж гүйцэтгэж ажиллалаа. Үүрэг чиглэлд заасан хугацаанд өөрийн харъяалах нэгжид бүртгэгдсэн бүртгэлийн жагсаалтыг мэдээллийн санд шалгаж, Иргэний улсын бүртгэлийг цахимжуулсан материалыг харах, ашиглах, засварлах программ хангамжаас бүрэн цахимжсан мөн нөхөн шивэлтээр бүртгэсэн, хоёр удаа санд орсон эсэхийг тус тус нотлох баримттай тулган шалгалаа. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд давхар бүртгэсэн 6 иргэний мэдээлэл бүртгэсэн төлөвтэй байна. Иймд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд зөрчлийг арилгах зорилгоор нэр бүхий 16 бүртгэлд хоёр удаа нөхөн шивэлтээр бүртгэсэн давхар бүртгэлийг Хяналтын улсын байцаагчийн 2023 оны 10 дугаар сарын 10 ны өдрийн №6199 дугаартай дүгнэлт гаргаж бүртгэлийг хүчингүй болгуулахаар иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүсэн. 6 иргэнийг гэрлэсний бүртгэл, гэрлэлт дуусгавар болсны бүртгэлд нөхөн шивэлтээр бүртгэсэн төлөвтэй бүртгэлийг дахин шалгаж баталгаажуулан ажиллалаа. Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн жагсаалтын дагуу 2006-2018 онд төрсөн 50 хүүхдийн ургийн овгийг мэдээллийн санд нэмэлт өөрчлөлтөөр оруулж зөрчил арилган ажилласан байна.

2. ХЭЛТСЭЭС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БУСАД АЖЛУУД

Нэг. Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал:

2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас зохион байгуулсан “Газрын багц хуулийн төслүүд болон Геодизи, зураг зүйн тухай хуулийн төсөл, Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-д санал авах тухай хэлэлцүүлэгт улсын бүртгэгч Ө. Батнасан оролцож саналаа өгч хамтран ажилласан.

Тус хэлтсийн Рэнчинлхүмбэ сумын улсын бүртгэгч П.Оргилсайхан нь сумын Засаг даргын тамгын газар болон ИТХ-ын төвлөрсөн орлогоос улсын бүртгэлийн киоск машины 26.800.000 /хорин зургаан сая найман зуун мянган/ төгрөгийг шийдвэрлүүлж, иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээ авах нөхцөл боломжийг улам ойртуулж, шинийг санаачлан ажилласан албан хаагч боллоо.

Тус хэлтэс нь аймгийн ЗДТГ, Цагдаагийн газар, ГХБХБГазар, ШШГГазар, ИХАШШ, ЗХАШШ, Прокурорын газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Нийгмийн даатгалын хэлтэс, ХХҮГазар, тойргийн нотариатууд, Татварын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Сумдын тамгын газрын дарга нар болон бусад байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцож хамтран ажиллаж байна.

2023 оны 03 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар”-аас томилогдсон ажлын хэсэг Ханх суманд ажиллан ОХУ-ын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгөнд газар дээр нь үзлэг шалгалт хийсэн бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын бүртгэгч Р. Нэргүй орж ажилласан. Уг үзлэгтэй холбоотой холбогдох нотлох баримтуудыг гарган өгч хамтран ажилласан.

2022 онд Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас шийдвэрлэсэн 53 600 000 төгрөгийн өртөг бүхий 2 ширхэг киоск машиныг иргэд харилцагчийн тоо хамгийн их байдаг төв ХААН банк буюу захын Төрийн банкны салбарт байршуулсан нь бүртгэлийн үйл ажиллагааг иргэдэд хүндрэл чирэгдэлгүй болж иргэд үйлчлүүлэгчдийн талархлыг хүлээж байна.

Тус хэлтсийн Цэцэрлэг сумын улсын бүртгэгч Д.Дэлгэрмөрөн нь сумын Засаг даргын тамгын газраас төсвийг шийдвэрлүүлэн “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлж, тус арга хэмжээнд оролцсон 3 гэр бүлд гэрлэлтийн “Андгай өргөх ёслол”-ыг зохион байгуулж ажилласан.

2023 оны 05 дугаар сарын 06-ны өдөр “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон суварга босгоё” аяны хүрээнд бүх нийтээр мод тарих өдөрт нэгдэж “Соёмбо” цэцэрлэгт хүрээлэнд 80 ширхэг бургас мод тарьсан.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/106 “Нийтийн эдэлбэр газрын хог хаягдал цэвэрлэх ажил зохион байгуулах тухай” захирамжийн дагуу байгууллагын ойр орчмын 50 метр хүртэлх газар болон хэлтэст хуваарьлагдсан 2 дугаар багийн баруун хэсгийн хогийг цэвэрлэсэн.

Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийг анхан шатны нэгжээс үзүүлэх ажлын хүрээнд аймгийн төвөөс хол, алслагдсан Тариалан, Цагаан-Уул, Цэцэрлэг, Их-Уул сумдад нэвтрүүлэхээр нийт 12.140.000 төгрөгийн төсвийг сумын ИТХ-р шийдвэрлүүлэн гадаад паспортын бүртгэл хөтлөх тоног төхөөрөмж /зургийн аппарат, гэрэлтүүлэгч иж бүрэн, хөшиг/ болон үйлчилгээний хураамж төлөх гэрэгэ пос төхөөрөмжийг худалдан авсан. Тус сумдын улсын бүртгэгч нарыг хэлтэст дадлага хийлгэж, гадаад паспортын эрхийг хөтлөх эрхийг нээлгэх албан бичгийг УБЕГ-т хүргүүлэн гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг 4 суманд үзүүлэх боломж бүрдэж байна.

Тосонцэнгэл сумын Засаг даргын тамгын газарт хүсэлт хүргүүлэн хүнсний ногоо тариалах зориулалт бүхий 1 га талбайг шийдвэрлүүлэн авч, албан хаагчдын хуримтлалын мөнгөнөөс 1.200.000 төгрөгний төмс бусад ногоог худалдан авч хүнсний ногоо тариалах ажлыг эхлүүлж 4 тонн төмсийг хураан авсан. Ингэснээр хэлтсийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, өөрсдийн санхүүгийн эх үүсвэртэй болох нөхцөл боломжийг бүрдүүллээ.

ГБХЗХГ, Мөрөн, Тариалан, Ханх, Шинэ-Идэр, Жаргалант сумын ЗДТГ-тай хамтран 6 удаагийн “Гэрлэлтийн андгай” өргөх ёслолыг зохион байгуулж Мөрөн сумын Иргэний гэр бүлийн 8н төрлийн бүртгэл хөтлөх өрөөг бүрэн тохижуулсан.

Аймгийн ЗДТГ-тай хамтран 15 суманд бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн 723 иргэнд үндэсний энгийн цахим гадаад паспорт олгож, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 272 иргэнд мэдээлэл өгж, 86 иргэнд гэрчилгээ олгосон. Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 53 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгж, 11 бүртгэл бүртгэж, гэрчилгээ олгосон.

2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр “Хүнс хөдөө аж ахуйн газар”, “Хоршоологчдын холбоо”, “Аймгийн засаг даргын тамгын газар” хамтран зохион байгуулсан “Хөвсгөл –Органик” хоршоодын зөвлөлдөх уулзалтанд Улсын бүртгэгч П. Даваадулам “Хоршооны шинэчилсэн бүтгэл”-ийн талаар мэдээлэл өгч хамтран ажиллалаа.

Хоёр. Нэгжийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд

Тус хэлтсээр үйлчлүүлж байгаа иргэдэд иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг авахад ойлгомжтой байхаар үйлчилгээний зааланд самбар, хаалга, цонх тус бүрийн хаягийг шинэчлэн монгол бичигтэй хосолмол бичвэртэйгээр байрлуулсан. Үйлчилгээний заалны дуу чимээ багасгах, өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, акустик хавтангаар ханыг ашиглан бүтээлч ажил хийсэн. Тус хэлтсээр өдөрт дунджаар 140 гаруй иргэн сард 3000 гаруй иргэн үйлчлүүлдэг учир мэдээ мэдээлэл авч болохуйц, дулаан тав тухтай орчныг бүрдүүлэхийг зорин ажиллаж байна.

Мөн эрх зүйн мэдээ мэдээллийн самбарыг шинээр хийлгэж байршуулсан бөгөөд мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн ажиллаж, 3н бүртгэлийн бүрдүүлбэрийн брошурыг хэвлүүлж иргэдийг мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.

Иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг ойртуулах, таниулах, сурталчлах цаг хугацаа хэмнэх зорилгоор бүртгэлийн үйлчилгээний төрөл тус бүрээр тайлбарласан мэдээллийн видео, баннарыг шинэчлэн бэлтгэж “Хөвсгөл аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс” фэйсбүүк хуудас болон хэлтсийн цахим хаягаар “Түгээмэл асуулт хариулт” буланд 7 хоног бүр байршуулж хэвшсэн.

2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар хэлтсийн 21 хурал, даргын зөвлөлийн 19 хурал тус тус болсон бөгөөд хурлын тэмдэглэлийг хөтлөн албажуулж, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хэлтсийн албан хаагчдад тухай бүрт танилцуулан, биелэлтийг хуулийн хугацаанд нь УБЕГ-т хүргүүлэн ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуудас болон фэйсбүүк хуудсанд оруулсан бүх мэдээ, мэдээллийг мөн хэлтсийн хэмжээнд зохион байгуулсан ажлын 216 мэдээ мэдээллийг хэлтсийн цахим хуудас болон фэйсбүүк хуудсанд байршуулан 761 удаа сурталчлан ажилласан байна. Цахим хуудас болон фэйсбүүк хуудсанд оруулсан мэдээллийг хэлтсийн нийт албан хаагчид болон сумдын улсын бүртгэгч нар иргэдэд тогтмол түгээн ажиллаж хэвшсэн.

Гурав. Идэвхи санаачлага, шинэлэг ажлын хүрээнд:

Тус хэлтэс нь Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын тамгын газар болон ИТХ-ын төвлөрсөн орлогоос улсын бүртгэлийн киоск машины 26.800.000 /хорин зургаан сая найман зуун мянган/ төгрөгийг шийдвэрлүүлж, иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээ авах нөхцөл боломжийг улам ойртуулж, шинийг санаачлан ажилласан албан хаагч боллоо.

Аймгийн Иргэдийн төлөлөөгчдийн хурлын төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлсэн 53 600 000 төгрөгийн өртөг бүхий 2 ширхэг киоск машиныг иргэд харилцагчийн тоо хамгийн их байдаг төв ХААН банк буюу захын Төрийн банкны салбарт байршуулсан нь бүртгэлийн үйл ажиллагааг иргэдэд хүндрэл чирэгдэлгүй болж иргэд үйлчлүүлэгчдийн талархлыг хүлээж байна.

Тус хэлтсээр үйлчлүүлж байгаа иргэдэд иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг авахад ойлгомжтой байхаар үйлчилгээний зааланд самбар, хаалга, цонх тус бүрийн хаягийг шинэчлэн монгол бичигтэй хосолмол бичвэртэйгээр байрлуулсан. Үйлчилгээний заалны дуу чимээ багасгах, өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, акустик хавтангаар ханыг ашиглан бүтээлч ажил хийсэн ба 3 баримтын архивт 3 ширхэг тавиур гагнуулж хийлгэсэн. Дээрх ажлын зардлыг багаж техник хэрэгсэл худалдан авах зардлаас нийт 2 310 000 төгрөгөөр худалдан авалт хийсэн бөгөөд албан хаагчид дотоод нөөц бололцоогоо ашиглан өөрсдөө хийж гүйцэтгэсэн.

Тус хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газраас дотоод сүлжээний 4G төхөөрөмжийг шийдвэрлүүлэн авч, 2023 онд 15 сумын 428 иргэнд тоон гарын үсэг олгох болон 723 иргэнд гадаад паспортын захиалга авах ажилд ашигласан байна.

Хэлтсийн байгууллагын архивын баримтыг цэгцлэх ажлыг зохион байгуулж, хадгаламжийн нэгжийн бүртгэлийг шинэчлэн бүртгэл хадгаламжийн нэгжүүдийг оноор, оны дотор хадгаламжийн нэгжүүдийг баримтын ач холбогдлоор нь дараалуулан байрлуулж, хадгаламжийн хугацаа дууссан баримт бичгийг устган ажилласан болно.

Тус хэлтэс нь “Эрхэм төрийн алба” хэмээх байгууллагын сүлд дууг бүтээн дүрсжүүллээ. Уг дууны үгийг “Ханх сумын улсын бүртгэгч Р.Нэргүй бичиж, аяыг Б. Хангай зохиосон ба дуучин И.Наранзаяагаар дуулуулсан. Дуу бүтээхэд гарсан холбогдох зардлыг хэлтсийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд тарьж ургуулсан төмсний ашгаас шийдвэрлэсэн.

Мөн манай хамт олноос гаргасан шинэ, шинэлэг санаачлагаар “Бүртгэлхүү, Бүртгэлмаа” нэртэй контентыг эхлүүлсэн бөгөөд эхний контентыг “Тоон гарын үсэг” сэдвээр бүтээж цахим хуудсанд байршуулаад байна. Энэхүү контент нь бүртгэл тус бүрээр цаашид үргэлжлэх бөгөөд шинэ контентыг тухай бүр цахим хуудаснаа байршуулан бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлан ажиллахаар төлөвлөж байна.

Тус хэлтсийн иргэний гэр бүлийн 8 төрлийн бүртгэлийн 101 тоот өрөөг Аймгийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран 1.780.000 /нэг сая долоон зуун наян мянга/-н төгрөгөөр тохижуулж, иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлэхэд эерэг таатай орчинг бүрдүүлэн ажиллаж байна.

Хэлтсийн хүүхдийн өрөөг шинээр тохижуулан, ашиглалтад оруулсан бөгөөд шинээр буйдан, цэцгийн тавиур, өрөөний гоёл чимэглэл зэргийн 460.000 /дөрвөн зуун жаран мянга/-н төгрөгийн төсвийг хэлтсийн албан хаагчдын өөрсдийн тарьж, ургуулсан төмсийг борлуулсан мөнгөөр тохижуулсан болно.

Тус хэлтсээс тэтгэгвэрт гарсан ахмадуудын нийгмийн баталгааг хангах, хүндэтгэл үзүүлэх ажлын хүрээнд өөрсдийн тарьж ургуулсан төмсний дээжээс 1,1 шуудай төмсийг өглөө.

Тус хэлтэс нь архивын 3 тавиурыг шинээр авч угсран хувийн хэргийг байрлуулаад байна. Мөн Монгол улсад бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 83 жилийн ой “Улсын бүртгэлийн ажилтын өдөр”-т зориулан “Архив-Бидний амьдрал” аяныг хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн зүгээс санаачлан зохион байгуулсан ба уг аяны хүрээнд шинээр угсарсан архивын тавиур дээр сумын газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргүүдийг байрлуулж, иргэний баримтын архив, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив, хуулийн этгээдийн архивын заагуурыг тус бүр шинэчлэн, тавиурын эгнээ бүр дээр байрлуулан галын булан, галын хорыг шинэчлэлээ.

Шинэ-Идэр сумын улсын бүртгэгч Н.Болормаа Улсын бүртгэлийн үйлчилгээнд суурилсан Энэхүү бүтээлд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ, өрх, хувь хүн нийгмийн харилцаанд оролцож үйлчилгээ авах ажил хөдөлмөр эрхлэхтэй холбоотой эрх зүйн мэдээллийг тусгасан. Өрхийн ширээний номыг Шинэ-Идэр сумын 520 өрхөд тараасан бөгөөд 2024 онд улсын бүртгэгчээс үйлчилгээ авсан /өмнө өгөөгүй/ өрхөд олгохоор төлөвлөөд байна.

Дөрөв. Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд

Цахим гарын үсгийн тухай хууль, Улсын бүртгэлийн байгууллагаас монгол улсын 16 насанд хүрсэн иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмын хүрээнд Аймгийн зооноын өвчин судлалын төвийн 23 албан хаагч, Мөрөн нисэх буудалын 32 албан хаагч, Нэгдсэн эмнэлэгийн 140 эмч, албан хаагч, Дулааны цахилгаан станцын 82 албан хаагч, Хаан банкны 173 албан хаагч, төрийн банкны 23 албан хаагч ХХААГазрын 13 албан хаагчид цахим гарын үсгийн тухай хууль, холбогдох журмын талаар мэдээлэл өгч тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулан ажилласан ба нийт 486 иргэнд тоон гарын үсэг олгож ажилласан байна.

Тус хэлтэс нь “Бүтээлч санаачлагаар-Бүртгэлээ эрчимжүүлье” аяныг зохион байгуулж Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоны улсын бүртгэгч нар аяны хүрээнд болон Хаан банк, Төрийн банк, ЕБСургуулийн ахлах ангийн сурагчдад тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулан аймгийн хэмжээнд 1175 иргэнд тоон гарын үсэг олгосон.

Аймгийн хэмжээнд тоон гарын үсэг авах 90464 иргэнээс өнгөрсөн оны тайлант хугацаанд 24372 иргэнд буюу 27%-тай байсан бол 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар нийт 51488 иргэнд тоон гарын үсэг олгож тоон гарын үсэг олгох ажил 57%-тай явагдаж, гүйцэтгэлийн төлөвлөгөө 100 хувь хэрэгжсэн.

Тав. Нээлттэй хаалганы өдөр

Хилийн боомт бүхий Ханх сумын ЗДТГазар, ИТХурлын хүсэлтийн дагуу Ханх суманд 2023 оны 02 дугаар сарын 01-02-ны өдөр “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулан ажиллалаа. Тус өдөрлөгөөр Үндэсний энгийн гадаад паспортын хүчинтэй хугацаа дууссан, шинээр захиалж байгаа 210 иргэний гадаад паспортын захиалга хүлээн авч холбогдох хууль журмын дагуу Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлж иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, иргэдийн цаг хугацаа, санхүү хэмнэж ажилласан байна.

Хөвсгөл аймгийн хамгийн их хүн амтай, улсын тэргүүний Тариалан сумын засаг даргын тамгын газартай хамтран 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулан ажиллаж иргэний улсын бүртгэл, эд хөрөнгий эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үлчилгээг үзүүлэн ажиллаж 204 иргэнд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 153 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 62 иргэнд үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээг олгосон байна.

2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Монголын хуульчдын холбоо, Аймгийн ЗДТГ-ын санаачлан зохион байгуулсан “БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА – ТАНЫ НҮДЭЭР” нээлттэй хаалганы өдөрт оролцож иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр зөвлөгөө мэдээллийг иргэдэд өгч, тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулсан.

Төсөв санхүүгийн хэмнэлттэй байгаатай холбогдуулан “Нээлттэй хаалганы” өдөр зохион байгуулах боломж хязгаарлагдмал байгаа ч сумын Засаг даргын тамгын газартай хамтран ажиллаж холбогдох зардлыг шийдвэрлүүлэн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хүргэх зорилт тавин ажиллаж байна. Аймгийн ЗДТГ болон хамтран 15 сумын ЗДТГ-тай хамтран бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн 723 иргэнд үндэсний энгийн цахим гадаад паспорт олгож, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 272 иргэнд мэдээлэл өгж, 86 иргэнд гэрчилгээ олгосон. Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 53 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгж, 11 бүртгэл бүртгэж, гэрчилгээ олгосон.

Зургаа. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

Хэлтсийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 5 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Тус хэлтэс нь 2023 оны 01 дүгээр сарын 12, 13-ны өдөр Орхон аймгийн Эрдэнэт хотын “Медикалл” эмнэлэгт албан хаагчдыг үзлэг оношилгоонд хамруулах ажлыг зохион байгуулсан бөгөөд 1 дүгээр ээлжинд 11 албан хаагч хамрагдсан. Мөн аймгийн Цээнэ хувийн эмнэлэгт 13 албан хаагч үзлэг оношилгоонд хамрагдсан.

Албан хаагчдын хуримтлалын санд суутгуулсан мөнгөнөөс албан хаагчдын өөрсдийн саналаар ижил өнгийн гадуур хувцас захиалан хийлгэж эхний ээлжинд аймгийн төвийн албан хаагчдыг жигдрүүлээд байна. Сумын бүртгэгч нарын хувцсыг 2023 оны 3 дугаар улиралд багтаан хийлгүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

2023 оны байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсан Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлын хүрээнд 11 албан хаагчийг Орхон аймаг дахь МЕДИКАЛ эмнэлгийн үзлэгт, 13 албан хаагчийн өөрсдийн хүсэлтээр Хөвсгөл аймгийн Цээнэ эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт тус тус хамрагдсан. Мөн тус хэлтсийн Баянзүрх, Галт, Жаргалант, Рэнчинлхүмбэ, Цагаан-Уул, Цэцэрлэг сумдын ЗДТГ-аас тус хэлтсийн улсын бүртгэгч нарыг УБ хотод эрүүл мэндийн багц үзлэгт хамруулж, хамтран ажиллах талаар ирүүлсэн албан бичгийн дагуу хэлтсийн зүгээс дээрх 6 сумын улсын бүртгэгч нарт 3-5 хоногийн чөлөөг олгон, үзлэг оношилгоонд хамруулсан.

Алаг-Эрдэнэ, Галт, Их-Уул, Тариалан, Улаан-Уул, Чандмань-Өндөр сумдын улсын бүртгэгч нарын гаргасан Глобал их сургуульд Эрх зүйч мэргэжлээр суралцан төгсөлтийн шалгалт өгөх хугацааны чөлөөний хүсэлтийг УБЕГ-т хүргүүлэн УБЕГ-н даргын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн тушаал гарж, чөлөөг олгосон хугацаанд бүртгэлийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн үргэлжлүүлсэн. Мөн хэлтсийн даргын чөлөөний хуудсаар ар гэрийн гачигдал гарсан болон зайлшгүй хүндэтгэн үзэх эрүүл мэндийн шаалтгаантай 21 албан хаагчдад чөлөө олгож ажилласан.

Архангай аймгийн Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Б.Батзоригийн эмчилгээний зардалд хандив өргөж, сайн үйлсийн аянд хамт олноороо нэгдсэн.

Монголын Цэргийн баярын өдрийг ойн хүрээнд ажил албан үүргээрээ бусад албан хаагчдаа манлайлсан 1 албан хаагчийг Төрийн дээд “Алтан гадас” одонгоор, 1 албан хаагчийг Төрийн дээд “Хөдөлмөрийн Хүндэт”, 1 албан хаагчийг “Улсын бүртгэлийн Тэргүүний ажилтан”-аар, 2 албан хаагчийг Хууль зүй дотоод хэргийн яамны “Хүндэт Жуух” бичгээр, нийт 5 албан хаагчийг шагналт тодорхойлон, шагналыг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр гардуулан ажиллалаа.

Нийгмийн баталгаа хангах төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хэлтсийн 3 албан хаагчийг Бүрэнтогтох суманд, 4 албан хаагчийг Мөрөн суманд газар олгуулах ажлыг зохион байгуулж сумын Засаг дарга нарт албан бичгийг холбогдох материалын хамт хүргүүлсэн. Үүнээс улсын бүртгэгч нар Н. Азжаргал, Нярав-Бичиг хэргийн эрхлэгч Б. Содномцэрэн нарт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 0.07 га газрыг олгуулахаар шийдвэрлүүлсэн.

3. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасаг нь 2023 оны жилийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар Монгол улсын Үндсэн хууль, Улсын Бүртгэлийн ерөнхий хууль, Гэр бүлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэл хөтлөх журам, Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх мэдээлэх журам болон холбогдон гарсан бусад дүрэм журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэх, иргэний хувийн нууцыг чандлан хамгаалах зарчмыг баримтлан ажиллалаа. Бүртгэлийн байгууллагын эрхэм зорилгын хүрээнд аймгийн нийт сумдад анхан шатны бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Нэг. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

Тайлант хугацаанд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр **41834** бүртгэлийг хуульд заасны дагуу, хугацаанд нь хөтлөн ажилласан байна. Үүнээс Төрсний бүртгэл 2080 үүнээс эрэгтэй 1058, эмэгтэй 1022, Гэрлэсний бүртгэл 522 үүнээс анхны гэрлэлт 428, дахин гэрлэлт 93, Гэрлэлт сэргээсний бүртгэл 1, Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 146, үүнээс захиргааны журмаар 33, шүүхийн журмаар 113, Үрчилсний бүртгэл 55, Эцэг /эх/ тогтоосны бүртгэл 104, Ургийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл 119, Нас барсны бүртгэл 745 бүртгэл хийгдэж цахим мэдээллийн санд баталгаажсан байна.

1991-1996 онд төрсөн иргэдийн төрсний бүртгэлд эцэг, эхийн регистрийн дугаарыг алдаатай буруу дутуу бүртгэснээс зөрчилтэй байгаа 63 иргэний бүртгэлийг /ИУБ маягт/ архиваас татан авч цахимжуулан хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр бүртгэлийн зөрчлийг арилгуулахаар улсын ахлах бүртгэгчид бүртгэл хөтлөн өгсөн. Мөн 1988, 1989, 2008 онд төрсөн иргэдийн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд алдаатай төлөвтэй байгаа 13 иргэний бүртгэлийн зөрчлийг арилгасан.

Гэрлэлтийн бүртгэл нь мэдээллийн санд бүртгэлгүй 32 иргэний бүртгэлийг цахимжуулан жагсаалтаар УБЕГ-т хүргүүлэн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулан зөрчлийг арилгасан. Мөн Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангийн нэрийн санд гэрлэлтийн төлөв өөрчлөх 66 иргэний хүсэлтийг хүлээн авч иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шалган ХУБайцаагчийн нэгдсэн дүгнэлтээр төлөв өөрчилсөн байна.

2004-2007 онд төрсөн хүүхдийн /бүртгэлд өөрчлөлт орсон/ 125 иргэний ургийн овгийг иргэний улсын бүртгэлийн нэрийн санд тусгахаар УБЕГ-ын ИБГ-т жагсаалтаар хүргүүлэн зөрчлийг арилгасан.

Хяналтын Улсын байцаагчийн дүгнэлт болон Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр регистрийн дугаарыг маягт Х-25-аар өөрчлөн 18 иргэний бүртгэлийг мэдээллийн санд оруулан ажилласан.

Хоёр. Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн чиглэлээр:

2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар Бусад аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 726 бүртгэл бүртгэж, үүнээс насанд хүрсэн 386, хүүхэд /16-аас доош насны/ 340, Сум хооронд шилжин ирсэн 1347 бүртгэл үүнээс насанд хүрсэн 740, хүүхэд /16-аас доош насны / 607, Баг хооронд шилжин ирсэн 1799 бүртгэл үүнээс насанд хүрсэн 883, хүүхэд /16-аас доош насны/ 916 иргэний бүртгэл хийгдэж цахим мэдээллийн санд баталгаажсан байна.

Баянзүрх, Тосонцэнгэл сумын ИТХурлын нөхөн сонгууль зохион байгуулах ажлын хүрээнд УБЕГ-ын даргын 2023 оны 4-р сарын 18 ны өдрийн А/829 тулаалын дагуу иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоон, бүртгэлд хяналт тавин ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023-ны А/600 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг /нөхөн, дахин/ хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө”-ий 4-д заасан “Шилжилт хөдөлгөөний бүртгэлд тогтмол хяналт тавих” арга хэмжээний биелэлтийг хангах хүрээнд хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч нарт хяналт шалгалт хийх чиглэл ирсний дагуу 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 04 дүгээр сарын 19-нийг дуустал хугацаанд аймгийн хэмжээнд бүртгэгдсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлд хяналт шалгалт зохион байгуулахад ямар нэгэн зөрчил илрээгүй болно. Мөн хэлтсийн даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2023 оны шилжилт хөдөлгөөний бүртгэлийн бүрдүүлбэр болон оршин суугаа хаягаа нотлох баримт бичгийг мэдээллийн сантай тулган шалгах ажлыг сумдын улсын бүртгэгч нарыг өөрсдийн хийсэн бүртгэлийг нэг бүрчлэн шалган илрүүлэх ажлыг 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 25-ны өдрийн дотор гүйцэтгэн үр дүнг илтгэх хуудсаар хүлээн авсан. Иргэний баримтын архивын тооллого хийх явцад илэрсэн бусад аймаг нийслэлийн хаягтай 3057 иргэний хувийн хэргийг харьяа аймаг нийлэлийн улсын бүртгэлийн хэлтэлт мөн бусад аймаг нийслэл рүү шилжин явсан 132 иргэний хувийн хэргийг тухайн шилжин очсон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст албан бичгээр хүргүүлсэн.

Гурав.Биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэл буюу Иргэний үнэмлэх олголт:

Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл буюу цахим үнэмлэх олголтын 6612 бүртгэл үүнээс шинэ 1833, дахин олгосон 2067, хорин таван насны сунгалт хийлгэсэн 1131, дөчин таван насны сунгалт 1550 бүртгэл хийгдэж 4516 иргэний цахим үнэмлэхний зураг засч сүлжээнд оруулан хэвлүүлсэн байна.

Нэрийн толинд нэр баталгаажуулах, ургийн овог, эцэг, эхийн нэр өөрийн нэр зөрүүтэй 40 иргэний мэдээллийг Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн зөрчил арилгаж иргэний цахим үнэмлэх хэвлүүлэн ажилласан байна.

Шинээр иргэний үнэмлэх авах насанд хүрсэн мөн 25 ба 45 насны сунгалт хийлгэх насанд хүрсэн боловч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирж биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамрагдах боломжгүй иргэдийг тухайн байгаа газарт нь очиж ИШБүртгэлд хамруулан бичиг баримтжуулах ажлыг тогтмол зохион байгуулж байна.

УБЕГазар, ИУБГазраас иргэний үнэмлэхийн бүртгэл, биеийн давхцахгүй өгөгдөл /ИУБ31/ бүртгэлтэй холбоотой зөвлөмж чиглэлийг цаг тухай бүрт сумдын улсын бүртгэгч нар мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.

Хурууны хээ давхардсан, зөрсөн 8 иргэний бүртгэлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр зөрчлийг арилгуулахаар ИУБГазарт хүргүүлсэн байна.

Энэ онд бүртгэл хөтөлсөн 4516 ИУБ -31 маягтын А талыг УБЕГ-ын улсын бүртгэлийн нэгдсэн архивт хүргүүлсэн бөгөөд Б талыг иргэний баримтын архивт хүлээлгэн өгч баяжилт хийгдсэн байна.

Дөрөв. Гадаад зорчих эрхийн бүртгэлийн хүрээнд:

Үндэсний энгийн гадаад паспорт захиалах ажлын хүрээнд нийт шинээр 6742 иргэний гадаад паспортын захиалга авч УБЕГазарт хүргүүлсэн бөгөөд хил орчмын нутаг дэвсгэрт хялбарчилсан журмаар зорчих үнэмлэх олгох буюу ОХУ-ын хавсралтын бүртгэл 2155 бүртгэгдсэн байна.

Хилийн бүс нутаг болох Ханх сумын ЗДТГазар, ИТХуралтай хамтран 2023 оны 2 дугаар сарын 01-02-ны өдөр Ханх суманд үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл хөтлөж 210 иргэнд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь түргэн шуурхай хүргэсэн байна. Мөн Тариалан сумын “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцож 148 иргэний үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл хөтлөн, хуулийн хугацаанд гадаад паспортын олголт хийж, Мөн алслагдсан сумдад “Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулах ажлын хүрээнд 2023 оны 9 дүгээр сарын 28-наас 10 дугаар сарын 5 ны өдрүүдэд Түнэл, Цагаан-үүр, Чандмань-өндөр, Эрдэнэбулган, Тариалан сумдад хүрч ажиллаж 215 иргэнд гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажилласан бөгөөд 10 дугаар сарын 26-27 ны өдрүүдэд Цагаан-Уул, 11 дүгээр сарын 02-ны өдөр Төмөрбулаг сумын 150 иргэнд гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн холбогдох хууль журмын дагуу Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлж иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, иргэдийн цаг хугацаа, санхүү хэмнэж ажилласан байна.

Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийг анхан шатны нэгжээс үзүүлэх ажлын хүрээнд аймгийн төвөөс хол, алслагдсан Тариалан, Цагаан-Уул, Цэцэрлэг, Их-Уул сумдад нэвтрүүлэхээр нийт 12.140.000 төгрөгийн төсвийг сумын ИТХ-р шийдвэрлүүлэн гадаад паспортын бүртгэл хөтлөх тоног төхөөрөмж /зургийн аппарат, гэрэлтүүлэгч иж бүрэн, хөшиг/ болон үйлчилгээний хураамж төлөх гэрэгэ пос төхөөрөмжийг худалдан авсан. Тус сумдын улсын бүртгэгч нарыг хэлтэст дадлага хийлгэж, гадаад паспортын эрхийг хөтлөх эрхийг нээлгэх албан бичгийг УБЕГ-т хүргүүлэн гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг 4 суманд үзүүлэх боломж бүрдэж байна.

Тав. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХурлын нөхөн сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу нөхөн сонгууль зохион байгуулах Баянзүрх, Тосонцэнгэл сумын нөхөн сонгууль зарлах тухай сумын ИТХ тогтоолыг хуулийн хугацаанд нь хүлээн авч улсын бүртгэлийн мэдээллийн санд шивж оруулсан.

Баянзүрх, Тосонцэнгэл сумын ИТХурлын нөхөн сонгууль зохион байгуулах ажлын хүрээнд 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/829 тушаалын дагуу иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоон, бүртгэлд хяналт тавин ажиллаж байна.

Нөхөн сонгууль бүхий сумдын сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу холбогдох хууль, журмын хүрээнд нятлан шалгаж 2023 оны 5-р сарын 22 ны өдөр хэвлэж, тухай сумдын сонгуулийн хороонд хуулийн хугацаанд хүлээлгэн өгч ажиллалаа.

Нөхөн сонгууль зохион байгуулах ажлын хүрээнд сонгуулийн өдөр итгэмжлэгдсэн ажилтны ажиллах ирц бүртгэлийн программ бүхий тоног төхөөрөмжийн иж бүрдлийг 2023 оны 06 дугаар сарын 05-07-ны хооронд УБЕГазраас хүлээн авахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Сонгуулийн СНЖагсаалт хэвлэгдэн сумын сонгуулийн хэсгийн хороонд хүлээлгэн өгснөөс хойш СНЖагсаалтад өөрчлөлт оруулах лавлагаа хэвлэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

2023 оны 6-р сарын 18 ны өдөр нөхөн сонгууль бүхий Баянзүрх, Тосонцэнгэл сумын улсын бүртгэгч нар итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллаж хуульд заасны дагуу ямар нэгэн алдаа дутагдалгүй ажиллалаа

Тус хэлтсийн шуурхай багийн бүрэлдэхүүн итгэмжлэгдсэн ажилтнуудыг мэргэжил арга зүйгээр хангаж, 11, 16, 20 цагийн мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж УБЕГазрын БТДШГазарт хүргүүлсэн ба Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн ИТХурлын нөхөн сонгуулийг амжилттай зохион байгуулсан байна.

Сонгууль зохион байгуулагдсан 2 сумын ирц бүртгэлийн программ бүхий тоног төхөөрөмжийн иж бүрдэлийг 2023 оны 6-р сарын 19-ний өдөр татан авч УБЕГазарт хүргүүлэн ажилласан байна.

Зургаа. Иргэний баримтын архивын ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд тус хэлтсийн иргэний баримтын архивын лавлагаа, Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн "Нээлттэй" мэдээллийг иргэдэд 12181, хууль хяналтын байгууллага болон бусад байгууллагад 1269, албан хэрэгцээнд 2824 лавлагаа нийт 16274 лавлагаа олгож ажилласан байна.

Иргэний баримтын архивт иргэний улсын бүртгэлийн 9630 ИУБ маягтуудын баяжилт хийж хураасан бөгөөд үүнд Төрсний бүртгэл /ИУБ-11/ 2080, Үрчилсний бүртгэл /ИУБ-12/ 55, Ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл /ИУБ-13/ 119, Эцэг тогтоосны бүртгэл /ИУБ-14/ 104, Гэрлэсний бүртгэл /ИУБ-15/ 522, Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл /ИУБ-16/ 146, Нас барсны бүртгэл /ИУБ-18/ 745, Биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэл /ИУБ-31/ 4519, шилжин ирсний бүртгэл /ИУБ-22/ 1836, бусад аймаг хотод бүртгэл хийлгэсэн, шилжин ирсэн 726 иргэдийн хувийн хэргийг иргэний баримтын архивт баяжилт хийсэн байна.

Иргэний улсын бүртгэл хөтлөх журмын 22.5 д заасны дагуу Иргэний улсын бүртгэлд бүртгүүлэхээр хууль тогтоомжид заасны дагуу бүрдүүлсэн баримт бичгийг 24 сумын улсын бүртгэгчээс татан авч хадгаламжийн нэгж 2022 оны бүртгэлийн 322 дэвтэр болон бүрдүүлбэрийг хадгалалтын стандартын шаардлагын дагуу хүлээн авч архивт баяжилт хийсэн байна.

Хяналтын улсын байцаагч болон тасгийн дарга, улсын бүртгэгч нар архиваас түр ашиглахаар 290 иргэний хувийн хэргийг захиалсан бөгөөд захиалгын хуудсын дагуу хүлээлгэн өгч буцаан авсан байна.

Иргэний бүртгэлийн мэдээллийн санд тухайн иргэний болон эцэг, эхийн мэдээлэл зөрсөн болон зөрчилтэй 290 иргэний ХААТР, ИУБ маягт, холбогдох бүртгэлийн дэвтрийн хуулбарыг мөн тухайн бүртгэлтэй холбоотой дэвтэр шүүж зөрчил арилгуулахаар улсын бүртгэгч Б.Дуламсүрэнд хүлээлгэн өгч зөрчлийг арилган ажилласан.

Хэлтсийн ББНШК-н 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрээр УБЕГ-ын дарга, АЕГ-ын даргын хамтарсан 2020 оны 11 сарын 02 өдрийн А/14371, А-110 тушаалын дагуу иргэний бүртгэлийн архивт хадгалагдаж байсан хадгалах хугацаа нь дууссан ИУБ21- 9025ш, 2016-2017 оны ИУБ-22 252 ширхэгийг тус тус баримтыг устгаж холбогдох акт, тайланг хугацаанд нь УБНА-ын газарт хүргүүлж ажиллалаа.

Иргэний баримтын архивын хувийн хэргийн сан болон ИГББ-ийн дэвтрүүдийг сэлбэн засаж, хувийн хэргийн санд хадгалагдах иргэдийн хувийн хэргийг тус бүр дугтуйлж, зориулалтын хайрцагт бичилт хийж тавиурт галигийн дагуу байршуулж байна.




Долоо. Цахим гарын үсэг олгох ажлын хүрээнд:

Цахим гарын үсгийн тухай хууль, Улсын бүртгэлийн байгууллагаас монгол улсын 16 насанд хүрсэн иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмын хүрээнд Аймгийн зооноын өвчин судлалын төвийн 23 албан хаагч, Мөрөн нисэх буудалын 32 албан хаагч, Нэгдсэн эмнэлэгийн 140 эмч, албан хаагч, Дулааны цахилгаан станцын 82 албан хаагч, Хаан банкны 173 албан хаагч, төрийн банкны 23 албан хаагч ХХААГазрын 13 албан хаагчид цахим гарын үсгийн тухай хууль, холбогдох журмын талаар мэдээлэл өгч тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулан ажилласан ба нийт 486 иргэнд тоон гарын үсэг олгож ажилласан байна.

Тус хэлтэс нь "Бүтээлч санаачлагаар-Бүртгэлээ эрчимжүүлье" аяныг зохион байгуулж Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоны улсын бүртгэгч нар аяны хүрээнд болон Хаан банк, Төрийн банк, ЕБСургуулийн ахлах ангийн сурагчдад тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулан аймгийн хэмжээнд 1175 иргэнд тоон гарын үсэг олгосон.

Аймгийн хэмжээнд тоон гарын үсэг авах 90464 иргэнээс өнгөрсөн оны тайлант хугацаанд 24372 иргэнд буюу 27%-тай байсан бол 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар нийт **51488** иргэнд тоон гарын үсэг олгож тоон гарын үсэг олгох ажил **57%**-тай явагдаж, гүйцэтгэлийн төлөвлөгөө 100 хувь хэрэгжсэн.

Ес. Иргэний улсын бүртгэлийн сүүлийн 3 жилийн судалгааг графикаар харуулав



4. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг нь тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Улсын тэмдэгтийн тухай хууль, Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Татварын ерөнхий хууль, Иргэний хууль, Нотариатын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол улсын засгийн газрын 2020.12.23-ны өдрийн 230 дугаар тогтоол, УБЕГ-аас ирүүлсэн чиглэл, журмын хүрээнд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх үл хөдлөх хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулж иргэнийг эдийн засгийн эрх чөлөөгөө эдлэх бүрэн боломжоор хангах зорилт тавин ажиллаж нийт **12391** мэдүүлэг хүлээн авч, холбогдох бүртгэлийг хөтлөн ажиллалаа.

Шинээр батлагдан гарсан хууль, тогтоомж болон цаг үеийн үйл ажиллагаатай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газар, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл, дүрэм журмуудыг уншиж судлан хэрэгжилтийг ханган холбогдох ажлуудыг зохион байгуулан ажиллалаа.

Тайлант хугацаанд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 14 чиглэл, зөвлөмжийг улсын бүртгэгч нарт тухай бүр танилцуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, 7 хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хийж хэрэгжүүлэн илтгэх хуудсыг хүргүүлэн ажилласан байна.

Иргэдээс “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.7-д заасан шалтгаанаар хувийн хэрэг хаалгахаар ирүүлсэн хүсэлт холбогдох баримт бичиг, мэдүүлгийг үндэслэн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 54, газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 11 хувийн хэрэг бүртгэлийг улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал болон хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үндэслэн тус тус хаасан байна. Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үндэслэн 1 бүртгэлийг хүчингүй болсон төлөвт шилжүүлсэн.

Мөн иргэн, хуулийн этгээдээс үрэгдүүлсэн гэрчилгээг дахин авах тухай өргөдөл хүсэлт, нотлох баримтыг үндэслэн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хүчингүйд тооцуулж үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 35, газар өмчлөх эрхийн 17 гэрчилгээг дахин олгож ажиллалаа.

Нэг. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэх

Газар өмчлөх эрх болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн анхны бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хуулийн хугацаанд түргэн шуурхай үзүүлж газар өмчлөх эрхийн бүртгэл нийт **381**, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл **762**-г бүртгэж нийт **1143** хувийн хэрэг шинээр үүсгэн архивт байрлуулсан байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хүлээн авсан мэдүүлгийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:



Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийг анх удаа бүртгэх бүртгэлийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:





Газар өмчлөх эрхийг анх удаа бүртгэх бүртгэлийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:




Хоёр. Барьцааны бүртгэл /ипотек/

Тайлант хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн барьцааны бүртгэлийн **5727** мэдүүлэг хүлээн авч бүртгэсэн ба үүнээс барьцаалбартай барьцааны гэрээ **1784**, барьцаалбаргүй барьцааны гэрээ **1219**, барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах **91**, барьцааны гэрээ дуусгавар болгох **2633**-г тус тус хүлээн авч бүртгэсэн. Мөн газар өмчлөх эрхийн барьцааны бүртгэлийн **3305** мэдүүлэг хүлээн авсан ба үүнээс барьцаалбаргүй барьцааны гэрээ **1729**, барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах **9**, барьцааны гэрээ дуусгавар болгох **1567**-ийг тус тус хүлээн авч бүртгэсэн байна. Түрээсийн гэрээ **1**, урьдчилсан тэмдэглэл **26**, урьдчилсан тэмдэглэл хүчингүй болгох бүртгэл **2**-г тус тус бүртгэсэн байна.



Гурав. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн шилжилтийг бүртгэх

Тайлант хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрээний бүртгэл **965**, газар өмчлөх эрхийн гэрээний бүртгэл **663** нийт **1628** мэдүүлэг хүлээн авч бүртгэл хөтөлсөн байна. Үүнээс бэлэглэлийн гэрээгээр **173**, ХХАГ-ээр **1067**, арилжааны гэрээгээр **10**, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх **200** хамтран өмчлөгч өөрчлөгдөх бүртгэлээр **169**, шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх **6**, албадан дуудлага худалдаагаар өмчлөгч өөрчлөгдөх **2**, бусад гэрээ хэлцлээр **1** бүртгэл тус тус бүртгэсэн байна.



Дөрөв. Эрхийн улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах




Тайлант хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нэмэлт өөрчлөлт оруулах **494** мэдүүлэг хүлээн авч холбогдох өөрчлөлтийг бүртгэсэн байна. Үүнээс үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр олгох-**52**, гэмтээсэн гэрчилгээ шинээр олгох-**6**, өмчлөгчийн овог нэр регистрийн дугаар өөрчлөгдөх-**4**, эд хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөх-**177**, эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх-**17**, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх-**190**, өмчлөгчийн хүсэлтээр бүртгэл салгаснаар хэмжээ өөрчлөгдөх **39**, газрын нэгж талбарын дугаар өөрчлөгдөх **9** тус тус бүртгэж, холбогдох материалыг архивт хүлээлгэн өгч ажиллалаа.

Тав. Лавлагаа хуулбар олголт:

Тайлант хугацаанд газар өмчлөх эрх болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн нийт **1601** лавлагаа олгосон байна.

Зургаа. Газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэл:



Аймгийн газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, сумын газрын даамлын газар эзэмших ашиглах эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхээр дундын мэдээллийн санд оруулж эзэмших эрхийн дугаар авсан **2604** бүртгэлийн дугаар олгосон хуудсыг хэвлэн авч архивын нэгж үүсгэн хадгалж байна

Долоо . Архив, мэдээллийн сан, үйлчилгээний хураамжийн талаар:

Архивын баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдалд байнгын хяналт тавин ажиллаж байна. 2023 оны архивын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу архивын хувийн хэрэгт тулгалт, тооллого хийх явцад 2009, 2010, 2011, 2012, 2013, 2014, 2015, 2017, 2018 онуудын хувийн хэрэг хаах материалыг иргэдээс хүлээн авсан боловч Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар хувийн хэрэг хаах тухай тушаал гаргуулаагүй, нотлох баримтыг хувийн хэрэгт шууд хавсаргасан хаагдаагүй зөрчилтэй 42 мэдүүлэг нотлох баримтын судалгааг гаргаж Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэн чиглэл авч ажиллалаа. Үүнээс нотлох баримт бүрэн 33 хувийн хэргийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан ЭХЭУБГ-т хүргүүлэн тушаал гаргуулж хувийн хэргийг хаасан. Үлдсэн 9 мэдүүлгийн нотлох баримт дутуу байсан тул өмчлөгчтэй нь холбогдон, нотлох баримтаа бүрэн гүйцэт бүрдүүлэн ирж, хувийн хэрэг бүртгэлээ хаалгахыг мэдэгдлээ. Мөн давхар бүртгэгдсэн 2 бүртгэлд хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулж, зөрчлийг арилгалаа.

2015 оноос хойш бүртгэгдсэн шинээр баригдсан орон сууцны бүртгэл болон, жагсаалтаар салж бүртгэгдэж байгаа орон сууцны бүртгэлүүдийг “EPRS2” цахим мэдээллийн сантай тулган шалгалаа. Борлуулагдаж дууссан орон сууцны хувийн хэргийг хаах, борлуулагдаж дуусаагүй бол өмчлөх эрхийн гэрчилгээгээ гаргуулсан захиалагч нарын хэмжээг хасуулж, өөрчлөлтийн бүртгэлээ хийлгэхийг холбогдох иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэн ажиллаж, 3 бүртгэлд хэмжээ өөрчлөх бүртгэлийг хийлээ.

2022 онд архивын хувийн хэргийн тооллого тулгалтын ажлыг хийж гүйцэтгэхдээ тусгаарлагдсан болон хасагдсан баримтуудыг ялган авч хадгаламжийн нэгж үүсгэсэн байсан ба уг баримтуудыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлэн 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдөр акт үйлдэн устгалд оруулсан.

2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн архивт газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 18572, газар өмчлөх эрхийн 13242, нийт 31814 хувийн хэрэг байна.

2023 онд шинээр 1143 хувийн хэрэг, нээж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт хүлээн авч байрлуулсан ба 11248 хувийн хэрэгт баяжилт хийсэн байна.

Хөрөнгөгүй болон үл хөдлөх эд хөрөнгийн лавлагааны мэдүүлэг нотлох баримтыг 250 нэгж үүсгэн багцалж үдэн архивын санд байршуулсан.

Тус хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газраас архивын зориулалтын 2 нягтруулсан тавиур шийдвэрлүүлсэн бөгөөд тавиурыг угсарч байрлуулан хувийн хэргийг байрлуулаад байна. Мөн Монгол улсад бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 83 жилийн ой “Улсын бүртгэлийн ажилтын өдөр”-т зориулан “Архив-Бидний амьдрал” аяныг хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн зүгээс санаачлан зохион байгуулсан ба уг аяны хүрээнд шинээр угсарсан архивын тавиур дээр сумын газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргүүдийг байрлуулж, архивын заагуурыг шинэчлэн тавиурын эгнээ тус бүр дээр байрлууллаа. Мөн галын булан, галын хорыг шинэчлэн байрлуулж, архивт эх цэвэрлэгээ хийсэн.

Иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн шинээр баригдсан нийтийн орон сууц, авто зогсоол, үйлчилгээний зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг захиалагч, хөрөнгө оруулагч, худалдан авагчийн нэрсийн жагсаалт, түүнд хавсаргасан нотлох баримтуудыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн систем /eprs/-д цахимжуулах ажлын хүрээнд орон сууцнуудын хувийн хэргийг татаж, ангилан ялгалаа.



Найм. Өргөдөл гомдол, мэдээ тайлан, хугацаатай албан бичгийн шийдвэрлэлт:

Тайлант хугацаанд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн талаарх тоон мэдээг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлж ажиллалаа.

Улсын бүртгэгч нар гэрчилгээ болон үнэт цаасны зарцуулалтын тайланг сар бүр гаргаж хэлтсийн ахлах нягтлан бодогчоор хянуулж тооцоо нийлэн ажиллаж байна.

Хөвсгөл аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Прокуорын газар, Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газраас ирүүлсэн **161** албан бичгийн хариу лавлагаа мэдээллийг хугацаанд хүргүүлсэн. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн албан бичиг тогтоол шийдвэрийн дагуу **46** эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийж, **45** эрхийн улсын бүртгэлийн тусгай тэмдэглэлийг хүчингүй болгосон байна. Мөн МИК-АКТИВ -30, 31, 32 ТЗК ХХК-ийн хүсэлтийн дагуу **81** эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийж бүртгэлээ.

Ес. Тэмдэгтийн хураамж, үйлчилгээний төлбөрийн талаар:

Тайлант хугацаанд **11248** хувийн хэрэгт үйлчилгээ орсон бөгөөд тус үйлчилгээний хураамж 136 922 253 / нэг зуун гучин зургаан сая есөн зуун хорин хоёр мянга хоёр зуун тавин гурав/ төгрөгийн мөнгөн орлогыг төвлөрүүлсэн ба үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхээ худалдан борлуулсны 2 хувь 410 623 531 / дөрвөн зуун арван сая зургаан зуун хорин гурван мянга таван зуун гучин нэг/ төгрөгийг, үл хөдлөх эд хөрөнгө анх удаа бүртгүүлсний тэмдэгтийн хураамжинд 21 477 692 /хорин нэгэн сая дөрвөн зуун далан толоон мянга зургаан зуун ерэн хоёр/ төгрөгийг тус тус татварын орлогод төвлөрүүлсэн байна. Тус хэлтэс нь “Гэрэгэ” пос машин, “Киоск” машинаар тус тус үйлчилгээний хураамжийг авч иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэж байна.

Арав. Анхан шатны нэгжээс эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн талаар:

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг сумынхаа иргэдэд хүргэх ажлыг Хатгал тосгоны улсын бүртгэгч М. Даваахүү, Цэцэрлэг сумын улсын бүртгэгч Д. Дэлгэрмөрөн нар хийж гүйцэтгэж байна. 2023 оны онд Улсын бүртгэгч Даваахүү нь нийт 252 бүртгэл хийснээс төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх 45, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийг анх удаа бүртгэх 24, өмчлөх эрх шилжих гэрээний бүртгэл 14, барьцааны гэрээний бүртгэл 159, бүртгэлд өөрчлөлт оруулах бүртгэл 10-ийг тус тус бүртгэсэн байна.

Цэцэрлэг сумын улсын бүртгэгч Д. Дэлгэрмөрөн нь нийт 52 бүртгэл хийснээс төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх 9, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийг анх удаа бүртгэх 6, өмчлөх эрх шилжих гэрээний бүртгэл 8, барьцааны гэрээний бүртгэл 29-ыг тус тус бүртгэн мэдүүлэг нотлох баримтыг 7 хоног бүр хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт ирүүлж байна.

Монгол улсад бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 83 жилийн ой, “Улсын бүртгэлийн ажилтны өдөр”-т зориулсан сумын улсын бүртгэгч нарын дунд “Бүтээлч санаачлагаар бүртгэлээ эрчимжүүлье” аяны хүрээнд Цэцэрлэг сумын улсын бүртгэгч Д. Дэлгэрмөрөн Цагаан-уул суманд 11 дүгээр сарын 13-наас 15-ны хооронд 3 өдөр ажиллаж нийт 10 бүртгэл хийсэн байна. Мөн дээрх аяны хүрээнд сумын улсын бүртгэгч нар идэвх санаачлагатй оролцож аяны хугацаанд Хатгал тосгоны улсын бүртгэгч нийт 19 бүртгэл, Цэцэрлэг сумын улсын бүртгэгч-11 бүртгэл хийсэн ба Арбулаг сум -2, Баянзүрх сум -6, Галт сум-16, Жаргалант сум-16, Их-Уул сум-12, Рашаант сум-8, Ренчинхүмбэ -6, Тариалан сум-39, Тосонцэнгэл-13, Төмөрбулаг сум-2, Түнэл сум-10, Улаан-Уул сум-4, Ханх-6, Цагааннуур сум-1, Цагаан-Үүр сум -4, Чандмань-Өндөр сум-15, Шинэ-Идэр сум-3, Эрдэнэбулган-3-г тус тус хүлээн авч Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэн холбогдох бүртгэлийг хийлгэсэн байна

Хэлтсийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Баянзүрх, Галт, Их-Уул, Тариалан, Улаан-Уул, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Шинэ-Идэр, Рашаант, Эрдэнэбулган сумын улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгох саналыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хүргүүлсэн ба Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар дээр ADB-ийн төсөл хэрэгжиж эхэлсэн бөгөөд улсын бүртгэгч нарыг чадавхжуулах сургалтыг 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр цахимаар зохион байгуулж дээрх 10 сумын улсын бүртгэгч хамрагдлаа. Энэ ондоо багтаж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгохоор ажиллаж байна.

Арван нэг. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл, зөвлөмж, үүрэг даалгаврын хүрээнд авч хэрэгжүүлсэн ажил:

Тус тасаг нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 7 хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хийж хэрэгжүүлэн илтгэх хуудсыг хүргүүлсэн. Мөн 14 чиглэл зөвлөмжийг улсын бүртгэгч нарт тухай бүр танилцуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Үүнд:

2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 6/277 дугаартай “Хугацаатай үүрэг даалгавар”-ын дагуу хавсралтанд тусгагдсан 7 бүртгэлийн хувийн хэргийг татаж, эх нотлох баримтыг цахим мэдээллийн сантай /Ergs2/ тулгалаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн Y-1707000323 дугаарт бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээг 0 гэж оруулсныг 66.1м.кв, Y1723007328 дугаарт бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээг 6м.кв гэж оруулсныг 66м.кв, Y-1723003996 дугаарт бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээг 6м.кв гэж оруулсныг 60м.кв, Y-1723010643 дугаарт бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээг 5176м.кв гэж оруулсныг 51.76м.кв болгон хяналтын улсын байцаагчийн 2022 оны 1500 дугаар дүгнэлт болон эх нотлох баримтад үндэслэн засвар өөрчлөлтийг хийж, зөрчлийг арилгасан.

Хавсралтанд дурьдагдсан эрхийн улсын бүртгэлийн Y-1723001947 дугаарт бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээ нь эх нотлох баримтад 9м.кв, Y-1723008571 дугаарт бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээ нь эх нотлох баримтад 536.2, Y-1723004152 дугаарт бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээ нь эх нотлох баримтад 1789.08м.кв.аар тус тус бүртгэгдсэн зөрчилгүй байсан тул өөрчлөлт оруулаагүй болно.

2023 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 5/1827 дугаартай чиглэлийг улсын бүртгэгч нарт танилцуулан, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 5/1854 дугаартай “Хугацаатай үүрэг даалгавар”-ын дагуу хавсралтанд тусгагдсан үл хөдлөх эд хөрөнгийн 25 бүртгэлийн хувийн хэргийг татаж, эх нотлох баримтыг цахим мэдээллийн сантай /Eprs2/ тулган, хяналтын улсын байцаагчийн 2022 оны 1500 дугаар дүгнэлт болон эх нотлох баримтад үндэслэн “хувийн хэрэг хаах” үйлчилгээ орсон боловч өмчлөгчийн төлөв өөрчлөгдөөгүй “Өмчилсөн” төлөвтэй байсан бүртгэлүүдийн төлвийг “Бүртгэл хүчингүй болсон” төлөвт оруулан засвар өөрчлөлтийг хийж гүйцэтгэлээ. Мөн эрхийн улсын бүртгэлийн Г-1723001392 дугаартай бүртгэлийн үйлчилгээний төрлийг “Хувийн хэрэг” гэж сонгох байсныг “хувийн хэрэг хаах” гэж сонгон цахимжуулсан зөрчлийг арилган засвар өөрчлөлт хийсэн.

2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 1/2559 дугаартай чиглэлийг Хэлтсийн дарга Б. Мөнгөнзул эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн хамт олонд танилцуулж, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг үүрэг болгосон. Уг чиглэлийг тус тасгийн хамт олон өдөр тутмын бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, хэрэгжилтэнд улсын ахлах бүртгэгч, хяналтын улсын байцаагч нар хяналт тавин ажиллаж байна.

2023 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 5/3231 дугаартай 8 заалт бүхий чиглэлээр Хяналт шалгалтын газрын хяналтын улсын байцаагчийн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хяналт шалгалт хийсэн тухай 06 дугаартай мэдэгдлийн дагуу шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэх, улсын бүртгэлийн болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, цаашид хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангаж ажиллахыг үүрэг болгосон. Уг чиглэлийг тасгийн улсын бүртгэгч нарт танилцуулан, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2023 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 5/4053 дугаартай зөвлөмж чиглэлийг улсын бүртгэгч нарт танилцуулснаас гадна аймгийн арилжааны банкууд болон ББСБ-уудад хуулбарлан хүргүүлж, заавар зөвлөгөө өгч ажилласан. Энэхүү чиглэлийг хүргүүлснээс хойш ЭУБ-06 маягыг буруу зөрүү үйлдэх, иргэдийг олон дахин явуулах зэрэг зөрчлүүд гарахгүй нэг мөр ойлголттой болсон.

2023 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 5/4053 дугаартай “Хугацаатай үүрэг даалгавар”-ын дагуу хавсралтанд тусгагдсан газар эзэмших эрхийн 283 бүртгэлийн хувийн хэргийг татаж, эх нотлох баримтыг цахим мэдээллийн сантай /Eprs2/ тулган, хяналтын улсын байцаагчийн 2022 оны 1500 дугаар дүгнэлт болон эх нотлох баримтад үндэслэн “газар эзэмших” эрхийн бүртгэлийг цахимжуулахдаа эзэмшигчийн төлвийг “Өмчилсөн” гэж цахимжуулсан 276 бүртгэлийн төлвийг “Эзэмшигч ашиглагч болсон” төлөвт оруулан засвар өөрчлөлтийг хийж гүйцэтгэсэн. Мөн эрхийн улсын бүртгэлийн Г-1706000422, Г-1706000086, Г-1706000183, Г-1707000059, Г-1710000170, Г-1713000145, Г-1713000036 дугаартай бүртгэлүүдийн өмчилсөн газрын зориулалтыг эзэмших гэж буруу оруулсныг “Газар өмчлөх ” болгон засвар өөрчлөлт оруулж зөрчлийг арилгасан ба засварласан бүртгэлүүдийн жагсаалтыг файлаар хүргүүлэн ажиллалаа.

2023 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 5/4618 дугаартай “Хугацаатай үүрэг даалгавар”-ын дагуу хавсралтанд тусгагдсан нэгж талбарын дугаар оруулаагүй 17 бүртгэлийн хувийн хэргийг татаж, эх нотлох баримтыг цахим мэдээллийн сантай /Eprs2/ тулган, хяналтын улсын байцаагчийн 2022 оны 1500 дугаар дүгнэлт болон эх нотлох баримтад үндэслэн нэгж талбарын дугаарыг нөхөж оруулан засвар өөрчлөлтийг хийж гүйцэтгэсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/953 дугаартай тушаалаар “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт ЭУБ-10” маягтад өөрчлөлт оруулан мөн Түрээсийн гэрээг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт ЭУБ-14, Түрээсийн гэрээний нэмэлт өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт ЭУБ-15 маягтуудыг шинээр батлуулан ирүүлсэн. Маягтууд батлагдсантай холбогдуулан 10 заалт бүхий чиглэл, 32 заалт бүхий 5/4664 дугаартай зөвлөмжийг 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдөр ЭХЭУБГ-аас ирүүлсэн. Уг зөвлөмж, чиглэлийг улсын бүртгэгч нарт нэг бүрчлэн танилцуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 5/5065 дугаартай зөвлөмж чиглэлийн дагуу 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 5/4618 дугаартай хугацаатай үүрэг даалгавраар ирүүлсэн нэгж талбарын дугааргүй 17 бүртгэлийн хувийн хэргийг татаж, эх нотлох баримтыг цахим мэдээллийн сантай /Eprs2/ тулган, хяналтын улсын байцаагчийн 2022 оны 1500 дугаар дүгнэлт болон эх нотлох баримтад үндэслэн нэгж талбарын дугаарыг нөхөж оруулсан.

Нэгж талбарын дугаарыг 0-00000000000000 гэж цахимжуулсан нэгж талбарын дугааргүй төрөөс хувьчилсан орон сууцууд буюу Мөрөн сумын 7, 8-р багийн барилгын 16 айлын орон сууц, гурил тэжээлийн үйлдвэрийн байр, эрчим хүчний үйлдвэрийн байр, 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18 дугаар байр гэсэн хаяг бүхий 656 бүртгэлд нэгж талбарын дугаар олгуулахаар аймгийн газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт албан бичиг хүргүүлсэн.

Мөн нэгж талбарын дугаарыг буруу цахимжуулсан, нэгж талбарыг дугаарыг 0-00000000000000 гэж цахимжуулсан бүртгэлүүдийн нэгж талбарын дугаарыг өдөр тутмын үйл ажиллагаагаараа засварлан шинэчлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 0-000000000000 гэж цахимжсан нийт бүртгэлийн судалгааг цахим мэдээллийн сангаас сум, багаар гарган мэдээллийн сангаас хаяг, болон өмчлөгчдийн мэдээллээр хайж нэгж талбарын дугаарыг олж хяналтын улсын ахлах байцаагчийн 1500 дугаар дүгнэлт үндэслэн засвар өөрчлөлт оруулах ажлыг хийж гүйцэтгэж байна.

2023 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 5/6223 дугаартай Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /eprs/-д бүртгэл хөтлөх, архивын үйл ажиллагааны талаар ирүүлсэн чиглэлийг улсын бүртгэгч нар болон архивч нарт танилцууллаа

Энэхүү эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /eprs/-д бүртгэл хөтлөхтэй холбоотой чиглэлд дурьдсан 11 заалтыг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Архивын үйл ажиллагаатай холбоотой заалтуудын хэрэгжилтийг ханган холбогдох маягт, дэвтрүүдийг бүрэн гүйцэт хөтлөн аймгийн улсын бүртгэлийн хэлтэс дээр бүртгэгдсэн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэг болон улсын бүртгэлд бүртгэгдсэн эрхийн улсын бүртгэлийн эх нотлох баримтыг өдөр өдөрт нь архивт хүлээн авч архивын баяжилт хийж хэвшсэн. Мөн суманд бүртгэгдсэн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэг болон улсын бүртгэлд бүртгэгдсэн эрхийн улсын бүртгэлийн эх нотлох баримтыг 7 хоног тутам архивт хүлээн авч архивын баяжилтыг хийж байна.

2023 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 5/7477 дугаартай чиглэлийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч нарт танилцуулан гадаадын иргэнтэй холбоотой эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөхдөө Гадаадын иргэн, харъяатын газраас цахимаар олгосон тодорхойлолтод бичигдсэн F-регистр болох 13 орон бүхий гадаадын иргэний бүртгэлийн дугаарыг цахим мэдээллийн сан /eprs/-д шивж, өмчлөх эрхийн гэрчилгээнд уг бүртгэлийн дугаарыг бичиж байхыг анхааруулан, хэрэгжилтийг ханган байна.

2023 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 5/783 дугаартай чиглэл, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023.08.24-ний өдрийн А/1614 дугаартай тушаалыг үндэслэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хаах бүртгэл нийт 10-ийг бүртгэж ажиллалаа.

2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 5/9855, 2023 оны 11 дүгээр сарын 06-нө дөрийн 5/10279 дугаартай чиглэлүүдийн дагуу Иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн шинээр баригдсан нийтийн орон сууц, авто зогсоол, үйлчилгээний зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг захиалагч, хөрөнгө оруулагч, худалдан авагчийн нэрсийн жагсаалт, түүнд хавсаргасан нотлох баримтуудыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн систем /eprs/-д цахимжуулах ажлын хүрээнд орон сууцнуудын хувийн хэргийг татан авч, ангилан ялгаж жагсаалтыг цахимжуулж тайланг 7 хоног бүрийн Баасан гарагт Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэн ажиллаж байна. 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар нийт 21 жагсаалт цахимжуулсан байна.

2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 5/9879 дугаартай судалгаа ирүүлэх албан бичгийн дагуу Хяналт шалгалтын газрын хяналтын улсын ахлах байцаагчийн 2022 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 1500 дугаартай дүгнэлт болон нэгжийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд засвар, өөрчлөлт оруулсан тухай тэмдэглэлийг 2022.01.01-нээс 2023.10.25-ны өдрийн байдлаар гарган файлаар хүргүүлсэн. Мөн 10 дугаар сарын тоон мэдээ, хувийн хэрэг хаасан тухай мэдээг шинэчлэн баталсан загвар маягтын дагуу гарган Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэн ажилласан.

2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 5/10482 дугаартай чиглэлийн дагуу 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс өмнө бүртгэж Г дугаар олгосон газар эзэмших, ашиглах эрх нь дундын мэдээллийн сангаар дамжуулан давхар Э дугаарт бүртгэгдсэн бүртгэлийн судалгааг гарган ажиллаж байна.

2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 5/10589 дугаартай чиглэлийн дагуу эрхийн улсын бүртгэлийн сангаас алгасаж унасан дугаарын жагсаалтыг гарган Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүллээ.

2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 5/10828 дугаартай чиглэлийг нийт улсын бүртгэгч нарт танилцуулан, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг үүрэг болголоо.

Арван хоёр. Бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах, аливаа зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:

Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч нь тасгийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, улсын бүртгэгч нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж, бүртгэлийн болон мэдээллийн сангийн үнэн зөв байдлыг хангах, улсын бүртгэгч нарыг аливаа эрсдэл, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлсөн мэдүүлэг, нотлох баримтуудыг өдөр бүр нэг бүрчлэн мэдээллийн сантай тулган шалгаж ажиллалаа. 2023 оны 11 дүгээр сарын 20-ны байдлаар 12391 бүртгэлийг цахим мэдээллийн санд шалгасан байна.

2023 онд хяналтын улсын ахлах байцаагчийн 1500 дугаар дүгнэлт болон нэгжийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үндэслэн нийт 120 бүртгэлд засвар өөрчлөлт оруулсан байна.

5. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус хэлтсийн хуулийн этгээдийн бүртгэл нь Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам, Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журам, иргэн, хуулийн этгээдийн тамга тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам болон бусад холбогдох хууль, журам, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Иргэний хууль, Нотариатын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, чиглэл, журмын хүрээнд хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэж нийт **616** иргэн хуулийн этгээдийн материал хүлээн авч ажилласан байна.

Нэг. Хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулах бүртгэл:

Шинээр **270** хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулан, шинээр үүсгэн байгуулагдсан **270** хуулийн этгээдийн материалыг хүлээн авч улсын бүртгэлд бүртгэж хувийн хэрэг нээн архивт хүлээлгэн өглөө. Үүнд:

Хязгаарлагдмал хариуцлагатай компани **220**,

Хоршоо **15**,

Төрийн бус байгууллага **30**,

Сан **3**,

Үйлдвэрчний эвлэлийн байгууллага **2**-г тус тус бүртгэж хувийн хэрэг үүсгэж цахимжуулан архивт хүлээлгэн өгсөн байна.

Мөн les.e.business.mn-ээр хүсэлт нийт **680** шинээр хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Хоёр. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн өөрчлөлт 346-г хүлээн авснаас:

Хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээгээ гээгдүүлсэн буюу гэмтээсэн бусад шалтгаанаар **52** /мэдээлэлд оруулсан өөрчлөлттэй давхардсан тоогоор/, хуулийн этгээдийн эрх шилжүүлэх болон өв залгамжлагчаар үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн, хаяг, дүрмийн сан, гишүүн нэмэх хасах бусад шалтгаанаар бүртгэлийн мэдээлэлдээ өөрчлөлт оруулсан **288**, татан буугдсан **6**-н хуулийн этгээдийн холбогдох материалыг хүлээн авч бүртгэн хувийн хэрэгт баяжилт хийн цахимжуулан архивт хуулийн хугацаанд хүлээлгэн өглөө.

Гурав. Иргэн хуулийн этгээдийн лавлагаа, хуулбар:

Хуулийн этгээдийн лавлагаа

- Иргэн, хуулийн этгээдийн лавлагаа 31,
- Төрийн байгууллагад лавлагаа 42 нийт 73 лавлагаа олгосон байна.

Хуулийн этгээдийн хувийн хэргээс хуулбар

- Иргэн, хуулийн этгээдэд хуулбар 21,
- Төрийн байгууллагад хуулбар 18, нийт 39 хуулбар олгосон байна.

Дөрөв. Архив, мэдээллийн сан:

2023.11.15-ны өдрийн байдлаар хуулийн этгээдийн архивт цахим санд бүртгэлтэй 3035, татан буугдсан 325 шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 135 нийт 3495 хуулийн этгээдийн хувийн хэрэг байршиж байна.

Шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 135 хуулийн этгээд.

№	Хэлбэр	Тоо
1	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	31
2	Төрийн бус байгууллага	33
3	Хоршоо	2
4	Сан	4
5	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	24
6	Бүрэн бус хариуцлагатай компани	12
7	Шашны байгууллага	7
8	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага	18
9	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	1
10	Хувиараа эрхлэх аж ахуй	1
11	Нөхөрлөл	2

Цахим санд бүртгэлтэй 3360 хуулийн этгээд.

№	Хэлбэр	Тоо
1	Хувьцаат компани	10
2	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	1934
3	Төрийн өмчит хувьцаат компани	1
4	Орон нутгийн өмчит хувьцаат компани	0
5	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	2
6	Бүх гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөл	72
7	Боловсрол сургалтын байгууллага	1
8	Төрийн бус байгууллага	350
9	Хоршоо	314
10	Хадгаламж зээлийн хоршоо	5
11	Төрийн байгууллага	210
12	Сан	18
13	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	3
14	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага	57
15	Шашны байгууллага	27
16	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	14
17	Банк бус санхүүгийн байгууллага	2
18	ГХО /ХХК/	10
19	ХХК /ТБОНӨӨ/	5
20	Татан буугдсан	325

Тав. Иргэн хуулийн этгээдийн тамга, тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох:

Иргэн хуулийн этгээдийн тамга, тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журмын дагуу **243**-н хуулийн этгээдийн болон хуулийн этгээдийн эрхгүй этгээдэд тэмдэг, баталгааны тэмдэгийн хяналтын дугаарыг олгож, 2023 оны 11 дүгээр сарын 20-ны байдлаар татан буугдсан, хэлбэр ашиглалтын шаардлага хангахгүй болсон бусад шалтгаанаар хураагдсан **47** ширхэг хуулийн этгээдийн тамга тэмдэг, баталгааны тэмдгийг хадгалалт хамгаалалтын шаардлага хангасан сейф шүүгээнд хадгалж, хуулийн хугацаанд нь устгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Зургаа. Мэдээ тайлан, хугацаатай албан бичгийн шийдвэрлэлт:

Сар бүрийн 25-наар тасалбар болгон хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээ, архивын мэдээ, үнэт цаасны тайлан, орлогын мэдээ, архивын орлогын мэдээг батлагдсан маягтын дагуу хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж холбогдох албан тушаалтанд цахимаар болон цаасаар хүргүүлэн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн хариутай албан бичгийг тогтоосон хугацаанд холбогдох мэдээ мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.

Хууль хяналт болон төрийн байгууллагаас ирүүлсэн **42** хугацаатай албан бичигт хуулийн хугацаанд хариу өгч, холбогдох материалыг хувийн хэрэгт хавсарган архивт хүлээлгэн өгч ажиллалаа.

Долоо: Орон нутгийн болон бүртгэлийн хэлтсийн дансанд төвлөрүүлсэн үйлчилгээний хураамж:

Орон нутгийн дансанд шинээр үүсгэн байгуулагдсан болон хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт, лавлагааны үйлчилгээний хураамж болох 13.054.000 /арван гурван сая тавин дөрвөн мянга/-н төгрөг, улсын бүртгэлийн дансанд хуулбар, нэрийн баталгаажуулалтын үйлчилгээний хураамж 6.421.000 /зургаан сая дөрвөн зуун хорин нэгэн мянга/-н төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна.

Найм. Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх ажил:

Хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулахын тулд утсаар давхардсан тоогоор **428** гаруй иргэдэд зөвлөгөө мэдээллийг өгч, оноосон нэрийн хүсэлтийг утсаар авч шүүн хариу илгээж, хуулийн этгээд шинээр байгуулах, нэмэлт өөрчлөлт бүртгүүлэхтэй холбоотой загвар маягтыг сумдын улсын бүртгэгчээр дамжуулан иргэдэд хүргүүлж хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй авах нөхцөл боломжоор ханган, зарим тохиолдолд үйлчилгээнд ашиглагдаж байгаа загвар маягтуудыг цахим шуудангаар илгээн ажилласан байна.

Мөрөн суманд 252, бусад сумдад 99 нийт аймгийн хэмжээнд 351 төрийн бус байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн төрийн бус байгууллагыг 23-н сумаар нь ялган excel файл үүсгэн сумдын улсын бүртгэгч нарт албан бичиг, тайлан ирүүлэх загвар хүснэгт, мөн тухайн сумдад үйл ажиллагаа явуулж байгаа 99 төрийн бус байгууллагын мэдээллийг хүргүүлэн ажилласан. Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж байгаа 252 төрийн бус байгууллагын үүсгэн байгуулагч нарт тайлангаа хуулийн хугацаанд ирүүлэх талаар утсаар зөвөлгөө өгч Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн цахим хуудас, Хөвсгөл аймгийн хэмжээний төрийн бус байгууллагын нэгдсэн групп /Хөвсгөл ТББ/-д төрийн бус байгууллагын тайлан ирүүлэх тухай мэдээлэл, тайлангийн загвар маягтыг тус тус байршуулан, төрийн бус байгууллагын үйл ажиллагааны тайлан ирүүлэх хуулийн хугацаанд 23 төрийн бус байгууллагын тайланг хүлээн авч нэгтгэн архивт хүлээлгэн өглөө.

2023 оны 03 дугаар сарын 30-нд Хөвсгөл аймгийн Тариалан суманд зохион байгуулагдсан “Нээлттэй хаалганы өдөр”-т оролцож төрийн байгууллагын албан хаагч болон иргэдэд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр мэдээлэл өгөн ажилласан.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, холбогдох журмуудын шинэлэг зохицуулалтын талаарх мэдээлэл, Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас гаргасан дүрсжүүлсэн гарын авлага мэдээллийг байгууллагын байранд байрлах дэлгэцээр гаргаж иргэдэд мэдээлэл түгээж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3-т заасан нээлттэй мэдээллийг хэрхэн танилцах, хуулийн этгээдийн лавлагаа, хуулийн этгээдтэй эсэх талаарх лавлагааг хэрхэн цахимаар авах талаар мэдээллийг иргэдэд цахимаар түгээн ажиллаж байна.

Ес. Бусад ажил

Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2023 оны 04 дүгээр сарын 03-ний өдрийн А/02 дугаар “Тооллогын комисс томилох тухай” тушаалын дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын баримтад тооллого хийх ажлыг зохион байгуулж архивт цахим санд бүртгэлтэй 3035, татан буугдсан 325 шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 135 нийт 3495 хуулийн этгээдийн хувийн хэргийн эх нотлох баримтыг цахим сантай тулган алдааг арилгах, цахимжуулах ажил 100% хийж гүйцэтгэсэн.

Хөвсгөл аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд “Хөвсгөл Гурил тэжээл” ХХК-ны нэхэмжлэлтэй Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтэст холбогдох маргаанд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт 3, шүүх хуралд 3 удаа итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон.

Санхүүгийн тайлангаа найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй хуулийн этгээдийн мэдээллийг нийтэж мэдээллэж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу нийтэд зарласнаас хойш 6 сарын дотор бичгээр санал, гомдол гаргаагүй хуулийн этгээдийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн “Хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах тухай” А/1345 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 4/7456 тоот чиглэлийн дагуу тусгаарласан.

Хуулийн этгээдийн цахим мэдээллийн санд байршуулсан Улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээдийн жагсаалтаас Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулах бүртгэлтэй 202 хуулийн этгээдийг тусгаарлан сан үүсгэх ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Арав. Төрийн байгууллагын хамтын ажиллагаа

Аймгийн Татварын хэлтэс, Тагнуулын ерөнхий газрын харьяа Хөвсгөл аймаг дахь хэлтэс, Статистикийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэстэй хамтран ажиллаж шинээр бүртгэгдсэн болон татан буугдсан аж ахуй нэгжүүд, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн судалгаа зэргийг улирал тутам тулган баталгаажуулан ажиллаж байна.


Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын алба ГХУСАЗСЭ, Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс, Монголын хуульчдын холбооноос санаачлан 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан “Бидний ажил таны нүдээр” нээлттэй хаалганы өдөрт оролцон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр мэдээ мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.

Хөвсгөл аймгийн засаг даргын 2023.06.21-ний өдрийн А/356 дугаар захирамжаар байгуулсан “Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын, татвар төлөгчдийн болон бусад бүртгэлийн мэдээллийг тодорхой болгох, татвар ногдох орлогыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх чиг үүрэг бүхий хяналт шалгалтын ажлын хэсэг”-т орж ажиллаж холбогдох мэдээллийг гаргаж татварын байгууллагад хүргүүлсэн.


2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр “Хүнс хөдөө аж ахуйн газар”, “Хоршоологчдын холбоо”, “Аймгийн засаг даргын тамгын газар” хамтран зохион байгуулсан “Хөвсгөл –Органик” хоршоодын зөвлөлдөх уулзалтанд Улсын бүртгэгч П. Даваадулам “Хоршооны шинэчилсэн бүтгэл”-ийн талаар мэдээлэл өгч хамтран ажиллалаа.

**Арван нэг. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн сүүлийн 3н жилийн мэдээг
графикаар харьцуулбал:**


**2021-2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ТАМГАНЫ ХЯНАЛТЫН ДУГААР
ОЛГОСОН БАЙДАЛ**




2021-2023 ОНД ТАТАН БУУГДСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД



2021-2023 ОНД ШИНЭЭР ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД



2021-2023 ОНД ХИЙСЭН БҮРТГЭЛИЙН ТОО



6. ХЯНАЛТЫН ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөвсгөл аймаг дах улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагч нь улсын бүртгэлийн алдаа, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн байгууллагын ажилтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавин ажиллахаас гадна алдаа зөрчлийг илрүүлэх, түүнийг таслан зогсоох, арилгуулах, улсын бүртгэлийн байгууллагын ажилтаны зөрчигдсөн эрх, ажил хэргийн нэр хүндийг сэргээх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах зорилгоор улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийн ажиллаж байна.

Нэг. Бодлого зорилтыг хангах чиглэлээр:

2023 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө болон ажлын байрны тодорхойлолтонд заагдсан Улсын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, илэрсэн зөрчлийг арилгуулах, улсын бүртгэлийн ажилтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих чиг үүргийн дагуу 3211 бүртгэлд хяналт тавьж ажиллалаа. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-2625, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр-254, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр-137, Улсын бүртгэлийн архивын чиглэлээр-195 тус тус шалгаж ажиллалаа. Шалгалтын явцад нийт 174 зөрчил илэрсэн бөгөөд Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-110, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр-64, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр-6, Улсын бүртгэлийн архивын чиглэлээр-0 тус тус зөрчил илэрсэн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/600 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Аймаг , нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг /нөхөн, дахин/ хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө”-ний 4-д заасан шилжилт хөдөлгөөний бүртгэлд тогтмол хяналт тавих арга хэмжээний биелэлтийг хангах хүрээнд хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч нь 2023 оны 01 дүгээр сарын 02-ний өдрөөс 04 дүгээр сарын 19-ны өдрийг дуустал хугацаанд бүртгэсэн бүртгэлийг шалгаж ажиллалаа. Энэхүү шалгалтаар Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлд заасан хяналтын үйл ажиллагаа болон шилжилт хөдөлгөөний бүртгэлд тогтмол хяналт тавих арга хэмжээний биелэлтийг хангах хүрээнд бүртгэлийг цахим хэлбэрээр хянаж, бүртгэл үнэн зөв байх зарчимд нийцүүлж ажиллалаа.

Үүрэг чиглэлд заасан хугацаанд өөрийн харъяалах нэгжид бүртгэгдсэн бүртгэлийн жагсаалтыг Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын алхах бүртгэгч, сумдын улсын бүртгэгч нараас бүртгэлийн дэвтэр, жагсаалтын хамт авч иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шалгаж, Иргэний улсын бүртгэлийг цахимжуулсан материалыг харах, ашиглах, засварлах программ хангамжаас бүрэн цахимжсан эсэх, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг EPRS-2 программаас үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний мэдээлэл буюу өмчлөгч, эзэмшигч, ашиглагч мөн эсэх, эрхийн улсын бүртгэл хүчин төгөлдөр эсэхийг Eprs-land.gasr.mn/eprsland/ буюу газрын дугаар олгох системд Э-дугаараар тулгаж үнэн зөв орсон эсэхийг тус тус нотлох баримттай нэг бүрчлэн тулгалаа

Шалгалтын хугацаанд Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шилжилт хөдөлгөөний бүртгэлийн чиглэлээр нийт 709 бүртгэлийг үнэн зөв бүртгэгдэж, баталгаажсан эсэх, шилжилт хөдөлгөөний бүртгэл тус бүрд авагдсан нотлох баримтын бүрдүүлбэр холбогдох хууль, журамд заасан шаардлагыг хангасан, бүрэн эсэхийг, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх, газар эзэмших эрхийн гэрчилгээний хаяг болон түрээсийн, захиалгын, худалдах худалдан авах гэрээнд тусгагдсан хаяг шилжин ирж буй хаягийн бүртгэлтэй тохирч байгаа эсэх, өмчлөгч, эзэмшигчийн бичгээр зөвшөөрөл өгсөн эсэхийг мөн шилжилт хөдөлгөөний бүртгэлийн ИУБ-22 маягтад бүртгүүлсэн иргэнээр гарын үсэг зуруулсан эсэх, шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэрт бүртгэл үнэн зөв бүртгэгдсэн эсэх тухайлбал үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигч, ашиглагч мөн эсэх, эрхийн улсын гэрчилгээ хүчин төгөлдөр эсэх, эх нотлох баримт бичиг бүрэн цахимжсан зэргийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нэг бүрчлэн тулгаж шалгалаа. Тус хяналт шалгалтаар Иргэний улсын бүртгэлийн шилжилт хөдөлгөөний бүртгэлд зөрчил дутагдал илэрээгүй бөгөөд хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын алхах бүртгэгч нар нь шилжилт хөдөлгөөний талаар цахим хурал хийж хууль, журамд нийцүүлэн бүртгэлийг өдөр бүр үнэн зөв, чанартай хийж гүйцэтгэж байх талаар улсын бүртгэгч нарт анхааруулан зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа.

Зөрчлийн хуулиар 25 иргэн, хуулийн этгээдэд торгууль оногдуулсан бөгөөд торгууль оногдуулсан хүн-23, торгууль оногдуулсан хуулийн этгээд-2 торгууль, шийтгэх хуудас бичиж Төрийн сангийн торгууль, хүү төвлөрүүлэх дансанд 1.460.000 төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Хоёр. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр


Иргэний улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд өдөр тутам хяналт тавихаас гадна иргэдийн өргөдөл болон улсын бүртгэгч нараас ирүүлсэн өргөдөл, төлөвлөгөөт болон түүвэрчилсэн зэрэг нийт 2625 бүртгэлд хяналт тавьж ажилласан байна. Үүнээс: Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр иргэний 8-н төрлийн бүртгэл-120, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлээр шинэ-150, 25,45 насны сунгалтаар-133, дахин авахаар-85, үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл-1030, шилжилт хөдөлгөөний бүртгэл-709 бүртгэлийг мэдээллийн санд эх нотлох баримт бичиг бүрэн цахимжсаныг тулгаж шалгасан байна.

Тус хяналт шалгалтаар Иргэний улсын бүртгэлийн үндсэн мэдээллийн санд эх нотлох баримт дутуу цахимжсан, нэршил буруу оруулсан зэрэг зөрчил илэрсэн алдаа зөрчлийг тухай бүр арилгуулан ажиллалаа.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр иргэдээс ирсэн өргөдөл, гомдол болон иргэний улсын бүртгэгчээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 104 дүгнэлт гаргаж Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлж зөрчил арилгуулсан байна.

- Дүгнэлтийн төрлөөр авч үзвэл:
- Нэмэлт өөрчлөлтөөр-59
- Регистрийн дугаар өөрчилж, дахин, шинээр олгох-27
- Бүртгэл хүчингүй болгох-17
- Бүртгэл сэргээх-1

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг /нөхөн, дахин/ хэрэгжүүлж ажиллах ажлын хүрээнд Баянзүрх, Тосонцэнгэл сумын иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг үнэн зөв хөтлөх, нотлох баримтыг хуульд зааснаар бүрдүүлэн авах, мэдээллийн санд үнэн зөв бүртгэх эсэх талаар шалгалт хийж мөн сонгогчийн нэрсийн жагсаалт хэвлэх явцад хяналт тавин ажиллалаа.



Гурав. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр өдөр тутмын болон түүвэрчилсэн, төлөвлөгөөт, улсын ахлах бүртгэгчээс ирүүлсэн өргөдөл зэрэг 254 бүртгэлд хяналт шалгалт тавьж ажиллалаа.

- Хяналтын улсын байцаагчийн нийт 64 дүгнэлт гарсан бөгөөд үүнээс:
- Эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгох-52
- Бүртгэлд өөрчлөлт оруулах тухай -4
- Бүртгэл хүчингүй болгох-3
- Хувийн хэргийг хаах тухай-4
- Бүртгэл түдгэлзүүлэх - 1

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн хөтөлж байгаа эсэх, түүний хадгалалт хамгаалалт, найдвартай байдлыг ханган ажиллаж байгаа эсэхэд байнгын хяналт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 254 бүртгэлийг мэдээллийн санд эх нотлох баримт үнэн зөв эсэх, бичиг баримт бүрэн цахимжсаныг тулгаж шалгасан байна.




Дөрөв. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу байцаагчийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон өдөр тутмын түүвэрчилсэн хяналтаар 137 бүртгэлийг мэдээллийн санд эх нотлох баримт бичиг бүрэн үнэн зөв цахимжсаныг тулгаж шалгасан байна.

Хяналтын улсын байцаагчийн нийт 6 дүгнэлт гарсан бөгөөд үүнээс:

➤ Тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгох-6

Хуулийн этгээдийн архивын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн хөтөлж байгаа эсэх, түүний хадгалалт хамгаалалт, найдвартай байдлыг ханган ажиллаж байгаа эсэхэд байнгын хяналт тавин ажиллаж байна.



Захиргааны хэргийн шүүхэд маргаантай байгаа асуудлаар:

Иргэн Л.Мялдорж болон нэр бүхий 17 иргэний нэхэмжлэлтэй Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 7480 дугаартай дүгнэлт нь Хөвсгөл гурил тэжээл ХХК-ийн хувьцаа эзэмшигч бидний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн тул хүчингүй болгож, Хөвсгөл гурил тэжээл ХХК-д миний болон миний төлөөлж байгаа хувьцаа эзэмшигчдийн хувьцааг бүртгэхийг даалгасан шийдвэрийг гаргуулах тухай нэхэмжлэлд мөн Л.Ганбатын “Хөвсгөл гурил тэжээл” ХХК-ний гүйцэтгэх удирдлагын мэдээлэлд 2009 онд орсон өөрчлөлтийг бүртгэхээс татгалзсан Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Улсын бүртгэлийн ерөнхий газрын эс үйлдэхүй нь хууль бус болохыг тогтоож, Хөвсгөл гурил тэжээл ХХК-ийн гүйцэтгэх удирдлагын 2009 оны өөрчлөлтийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэхийг Хөвсгөл аймгийнх Улсын бүртгэлийн хэлтэст даалгах тухай” нэхэмжлэлд, нэхэмжлэлийн шаардлага ихэсгэж “Хөвсгөл гурил тэжээл” ХХК-ийн хувьцаа эзэмшигч болон гүйцэтгэх удирдлагын өөрчлөлтийг бүртгэсэн улсын бүртгэгч Н.Азжаргалын 2023 оны 03 дугаар сарын 25-ны бүртгэлийг хүчингүй болгох” нэхэмжлэлтэй, захиргааны хэргийг хянан шийдвэрлэх анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн ажиллагаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр нэхэмжлэлийн хувийг гардан авах, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2, 21.2 дахь хэсэгт заасан хариуцагчийн эрхийг эдэлж, үүрэг хүлээх, мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1, 28.2.1, 28.2.6, 28.2.8 дахь заалтад заасан төлөөлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэн шүүх хуралд тус тус оролцож байна.

Тав. Архив, мэдээллийн сангийн чиглэлээр:

Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгт хамаарах улсын бүртгэлийн мэдээллийн сан, архивын баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдалд байнгын хяналт тавин ажиллаж Улсын бүртгэлийн архивын чиглэлээр 195 бүртгэлд хяналт тавьж ажиллалаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Архивын ерөнхий газрын даргын хамтарсан 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/1437, А/110 дугаар тушаалын хавсралт, Улсын бүртгэлийн нэгдсэн архивын даргын 2020 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн 11/9747 дугаартай чиглэл, зөвлөмж, УБН архивын даргын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 10/601 дугаар чиглэл зэргийг үндэслэн тус хэлтсийн байгууллагын ББНШАЗК-ын 2022 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, батлуулах, хөтлөгдөж дууссан баримт бичгийг устгах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн архивт хадгалагдаж байсан хадгалах хугацаа нь дууссан ИУБ-21 маягт, ИУБ-22 маягт, шилжилт хөдөлгөөний бүрдүүлбэр, хүчингүй болгосон иргэний бичиг баримт, гадаад паспортын сунгалтын дэвтэр, лавлагаа олгосон бүртгэлийн дэвтэр, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийн захиалгын хуудас зэргийг баримт бичиг нягтлан шалгах комиссын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хурлын тэмдэглэл, устгах актын дагуу 10000 гаран баримт бичгийг Мөрөн сумын хогийн цэгт комиссын гишүүд устгалд оруулж ажиллалаа.

7. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус хэлтэс нь 2023 онд батлагдсан 1 584 448 700 төгрөгийн төсвөөс 10 сарын байдлаар 1 522 297 400 төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 237 415 093 төгрөгийг оруулж улсын төсөвт төвлөрүүлээд байна.

Сар бүрийн орлогын мэдээг тасгуудаас ирүүлсэн мэдээг нэгтгэн УБЕГазарт хүргүүлж байгаа бөгөөд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг УБЕГазраас ирүүлсэн чиглэлийн дагуу орлогын нэр төрөл, мөнгөн хөрөнгийн данс бүрээр, өглөг авлагын задаргаа бүрээр цаг хугацаанд чанартай гарган УБЕГазарт хүргүүлэн, Шилэн дансны сайт, Хөвсгөл УБХэлтсийн мэдээллийн сайт, байгууллагын “Санхүүгийн ил тод байдлын” самбарт нээлттэйгээр байрлуулан ажиллаж байна. Мөн Шилэн дансны сайтад Гадаад паспортын шинэчлэгдсэн үйлчилгээний үнэ тариф, 2022 оны аудитын дүгнэлт, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн мэдээ тайланг цаг хугацаанд нь шивэн оруулж 2023 оны 3 дугаар улирлын шилэн дансны тайланг илгээсэн болно.

Бүртгэгч нарын 2023 оны 1-10 сарын үнэт цаасны кодтой тайланг хугацаа хоцроогүй нэгтгэн УБЕГазрын санхүүд хүргүүлээд байна.

2023 оны 3 дугаар улирлын тайлан балансыг УБЕГазарт хүргүүлэн, Сангийн яамны сайтад шивж оруулаад байна.

2023 оны Орон нутгийн нөхөн сонгуулиар 4 750 000 төгрөгийн санхүүжилт хийгдэн, батлагдсан хуваарийн дагуу зарцуулахаар ажиллаж байна.

Сангийн яамнаас хэрэгжүүлж буй онлайн программ болох цалин хөлсний PAYROLL программ, төрийн сангийн төлбөр тооцооны Finance программуудаар нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээгээ хийж гүйцэтгэж байна. Мөн ХЗДХЯамнаас хэрэгжүүлж буй төсвийн гүйцэтгэлийн OPENGOV программд сар бүрийн төсвийн гүйцэтгэл болон 2024 оны төсвийн төслийг шивж оруулаад байна.

Ажиллагсдын цалингийн тооцооллыг сард 2 удаа бодож, 2 программаар бодон тулган шалгаад, Нийгмийн даатгалын тайланг цалингийн программаас Нийгмийн даатгалын сайт руу excel файл руу хөрвүүлэн илгээж байгаа.

Хүний нөөцийн нэгдсэн системээс албан хаагчийн цалинтай холбоотой мэдээллийг сар бүр шинэчлэн татаж тулган баталгаажуулан цалинг тооцоолон татварын суутганы тайланг PAYROLL программаас татан оруулж тайлангаа цаг хугацаанд нь илгээн ажиллаж байна.

Тайланг хугацаанд УБЕГазраас татан авах үнэт цаас, бараа материалыг машин техник хүн хүчний боломжоороо тасралтгүй ханган байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг тасалдуулалгүй ажиллаж байна.

Сумдын улсын бүртгэгч нарын үнэт цаасны тайланг код бүрээр тулган баталгаажуулж заасан хугацаанд нь УБЕГазрын санхүүд нэгтгэн хүргүүлж байна.

8. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Хэлтсийн нярав, бичин хэргийн ажилтан нь байгууллагын ирсэн, явсан бичгийн бүртгэл хөтөлж, хариутай бичгийн шийдвэрлэлтэнд хяналт тавьж ажиллалаа. Тус хэлтэс нь тайлант хугацаанд 1341 албан бичгийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажласан бөгөөд 1550 албан бичгийг хүлээн авсан үүнээс 879 нь хариутай албан бичиг байсан ба холбогдох хариуг цаг хугацаанд нь шийдвэрлэж хүргүүлсэн. Нийт бичиг хэргийн эргэлтийн тоо 1550. Тайлант хугацаанд Хэлтсийн даргын 21 тушаалыг бүртгэж ажилласнаас байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 2, хүний нөөцтэй холбоотой Б тушаал 21-г тус тус гарган хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Мөн тайлант хугацаанд улсын бүртгэлтэй холбоотой асуудлаар иргэдээс нийт 122 өргөдөл, гомдол ирсэн ба өргөдөл, гомдлыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд нь хуваарилан, шийдвэрлүүлж, 3 өргөдөл гомдлын шийдэвэрлэх хугацаа болоогүй хүлээгдэж байна. Бичиг хэргийн цахим программ болох ERP болон EDOC програм, Khuvsgul@burtgel.gov.mn, uburtgel@khs.gov.mn, 21aimag@burtgel.gov.mn төрийн цахим хаягаар бусад байгууллагаас ирүүлсэн албан бичгийг хүлээн авч, холбогдох албан хаагчид шилжүүлэн хариутай албан бичгийн хариуг хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын хэмжээнд тоон гарын үсэг ашиглаж эхэлсэнтэй холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэх албан бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулан EDOC програмаар хүргүүлж, бичиг хэргийн зардлыг хэмнэн ажиллаж хэвшсэн байна. Хэлтсийн байгууллагын архивын баримтыг цэгцлэх ажлыг зохион байгуулж, хадгаламжийн нэгжийн бүртгэлийг шинэчлэн бүртгэл хадгаламжийн нэгжүүдийг оноор, оны дотор хадгаламжийн нэгжүүдийг баримтын ач холбогдлоор нь дараалуулан байрлуулж, хадгаламжийн хугацаа дууссан баримт бичгийг устган ажилласан болно.

Хэлтсийн албан бичгийн 2023 оны жилийн эцсийн эргэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:

Он	Ирсэн бичиг			Явсан бичиг	Хэлтсийн даргын тушаал			Өргөдөл гомдол
	Хариутай	Хариугүй	Нийт		А тушаал	Б тушаал	Нийт	
2021 оны жилийн эцэс	550	231	781	1452	17	10	27	79
2022 оны жилийн эцэс	988	441	1439	1344	12	22	34	42
2023 оны жилийн эцэс	879	671	1550	1341	2	21	23	122

Албан бичгийн эргэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:



Иргэдээс ирүүлсэн өргөдлийг төрлөөр нь авч үзвэл:

- Иргэний бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 44 өргөдөл
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 5 өргөдөл
- Хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой – 3 өргөдөл, 9 хүсэлт
- Бүртгэлийн хяналтын үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 59 өргөдөл
- Албан хаагчтай холбоотой гомдол – 2
- Албан хаагчийн нийгмийн асуудал болон хүний нөөцтэй холбоотой асуудлаар – 0
- Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 0 нийт 111 өргөдөл, 9 хүсэлт, 2 гомдол хүлээн авсан байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдлийн шийдвэрлэлтээр авч үзвэл:

- Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 61
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газарт албан бичгээр хүргүүлсэн 52
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар ирсэн 9 хүсэлтэд тухай бүрт 3 удаа албан бичгээр, утсаар 3 хариу хүргүүлсэн.
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой өргөдлийг УБЕГ-ын ЭХЭУБГ-т албан бичгээр хүргүүлэн шийдвэрлүүлсэн.
- Өргөдөл гомдлын шийдвэрлэх хугацаа болоогүй 3 өргөдөл хүлээгдэж байна.

9. СУРГАЛТ, СЕМИНАР БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Хэлтэст зохион байгуулах 2023 оны сургалтын төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр боловсруулж хэлтсийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу холбогдох сургалтанд хамрагдаж байгаа бөгөөд тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 19, Улсын бүртгэлийн ерөнхий газраас болон аймгийн ЗДТГ, бусад байгууллагаас зохион байгуулсан нийт 49 удаагийн сургалтад хэлтсийн бүх албан хаагчид болон хэлтсийн дарга, холбогдох албан хаагчид бүрэн хамрагдсан байна. Мөн аймгийн Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучууд хөгжлийн газар, Хүний эрхийн үндэсний комисс, Тагнуулын байгууллагын сургалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтыг хэлтсийн албан хаагчдад танхимаар зохион байгуулсан.

1.Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй сургалт:

- 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн Авлигаас урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал сургалтад 36 албан хаагч
- 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн орчин сургалтад 37 албан хаагч
- 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлага сургалтад 35 албан хаагч
- 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Монгол орны хөгжлийн хэтийн төлөв сургалтанд 36 албан хаагч
- 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн Төрийн албан хаагч сургалтад 34 албан хаагч
- 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн Төрийн албаны шинэтгэл сонгон шалгаруулалтын зохицуулалт сургалтад 39 албан хаагч
- 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн Стрессийг зохицуулахад Таны оролцоо сургалтад 40 албан хаагч
- 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн Цахим шилжилт сургалтад 38 албан хаагч
- 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн Бүтээмжээ нэмэгдүүлэх нь сургалтад 36 албан хаагч
- 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Өсөлтийн сэтгэлгээ сургалтад 37 албан хаагч
- 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн Чингис хаан Монголчуудын үнэт зүйл болох нь ба өнөө үе сургалтад 36 албан хаагч
- 2023 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн Зөөлөн менежмент сургалтад 39 албан хаагч 2023 оны 6 дугаар сарын 07-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалтын “Хувь хүний хөгжлийг дэмжих амьдрах стратеги” сургалтад хэлтсийн 25 албан хаагчид
- 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Монгол улсын уртхугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат шинэ сэргэлтийн бодлого Алсын хараа 20:50 сургалтад иргэний тасгийн улсын бүртгэгч Б.Батжаргал, Ө.Түвшинсайхан
- 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалтын “Төрийн албан хаагч ба дипломат ёслол”, “D-Өргөдөл” сургалтуудад хэлтсийн 28 албан хаагчид

- 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалтын “Аз жаргалтай ажилтан” сургалтад хэлтсийн 38 албан хаагчид
- 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалтын Аз жаргалтай ажлын байр стресс менежмент сургалтад хэлтсийн 34 албан хаагчид
- 2023 оны 11 дүгээр сарын 09-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалтын Амжилтад хүрэх хүсэл сэдэвт сургалтад хэлтсийн 26 албан хаагчид
- 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалтын Шинэ зууны манлайлын хэв маягууд сэдэвт сургалтад хэлтсийн 21 албан хаагчид хамрагдсан

2. Улсын бүртгэлийн Ерөнхий газар болон аймгийн ЗДТГ-с зохион байгуулсан сургалт:

2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас зохион байгуулсан “Газрын багц хуулийн төслүүд болон Геодизи, зураг зүйн тухай хуулийн төсөл, Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-д санал авах тухай хэлэлцүүлэгт улсын бүртгэгч Ө. Батнасан оролцож саналаа өгч хамтран ажиллалаа.

2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн “Аймаг дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн улсын ахлах бүртгэгч нарт зориулсан танилцуулах, чиглэл өгөх” сургалтад иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Өлзийням

2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ИХБ Төвийн сургагч багш, шим тэжээл судлаач, хоол зүйч, ШУ-ны магистр Э.Нэмүүзолын “Эрүүл зөв зохистой хооллолт” сэдэвт сургалтад хэлтсийн бүх албан хаагчид

2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн Програмын танилцуулах сургалтад иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга улсын ахлах бүртгэгч Б.Өлзийням, иргэний улсын бүртгэгч Б.Мөнхзул, С.Тэмүжин нар

2023 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан “Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан зохион байгуулсан” сургалтад иргэний улсын бүртгэгч С.Тэмүжин

2023 оны 03 дугаар 07-ны өдөр Гэр бүл хүүхэд залуучууд хөгжлийн газраас зохион байгуулсан “Анзаар” сургалтад хэлтсийн дарга Б.Мөнгөнзул

2023 оны 03 дугаар сарын 16-17-ны өдөр зохион байгуулагдсан “Удирдах ажилтны” сургалтад хэлтсийн дарга Б.Мөнгөнзул

Хөвсгөл аймгийн Цагдаагийн газраас 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан “Хүүхдийн эрхийн хамгаалалт, бэлгийн халдашгүй байдал” сэдэвт сургалтад хэлтсийн бүх албан хаагчид

Хөвсгөл аймгийн Цагдаагийн газраас 2023 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр зохион байгуулсан “Гэр бүлийн харилцаа” сэдэвт сургалтад хэлтсийн бүх албан хаагчид

2023 оны 04 дүгээр сарын 13-наас 15-ны өдрүүдэд Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан “Гамшгаас хамгаалах команд штабын сургуулилт”-ын Ажиллагааны багт хэлтсийн дарга, тасгийн дарга болон улсын ахлах бүртгэгч нар

УБЕГ-ын ЭХЭУБГазраас 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн улсын бүртгэгч, улсын ахлах бүртгэгч нарыг чадавжуулах, бүртгэл хөтлөх болон цахим системийн боловсруулалтад анхаарах асуудлын талаар зөвлөмж чиглэл өгөх” зорилго бүхий онлайн сургалтад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн бүртгэгч нар

2023 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр Хүний эрхийн үндэсний комиссын Хөвсгөл аймаг дах гишүүн Тунгалагмөрөнгийн “Хүний эрхэд суурилсан хандлага” сэдэвт сургалтад хэлтсийн бүх албан хаагчид

2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Хяналт шалгалтын газраас зохион байгуулсан “Хяналт шалгалт, зөрчлийн нэгдсэн санд мэдээлэл боловсруулах, цахимжуулах явцад гарч байгаа анхаарах асуудал” сэдэвт цахимаар сургалтад хяналтын улсын байцаагч С.Отгон-Өлзий

2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын газраас зохион байгуулсан “Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр”-т зориулсан сургалтад хэлтсийн бүх албан хаагчид

2023 оны 05 дугаар сарын 07-09-ний өдрийн Орон нутаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн иргэний улсын ахлах бүртгэгч нарын танхимын сургалтад Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Өлзийням

2023 оны 05 дугаар сарын 12-18-ны өдөр “Дэмч Ир Гүн” сургалтын төвөөс зохион байгуулсан ХАБЭА-ын мэргэшсэн ажилтан бэлтгэх 124 цагийн танхимын сургалтад тус хэлтсийн ХАБЭА хариуцсан ажилтан Б.Оюунцэрэн оролцож сургалтын төлбөр болох 600.000 /зургаан зуун мянган/ төгрөгийг хэлтсээс шийдвэрлэж, мэргэшлийн сертификат авсан.

2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр ХААН банкнаас “Интернет банкаа хэрхэн ашиглах, мөн хуримтлалын данс нээх” сэдэвт сургалтад хэлтсийн бүх албан хаагчид

2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Монгол улсын үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэлэлцүүлэгт хэлтсийн бүх албан хаагчид хамрагдаж, санал асуулгад оролцсон

2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн зүйн хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хамтарсан “Төрийн байгууллага, албан хаагчдын сахилга, ёс зүйн нэгдсэн зөвөлгөөн” сэдэвт сургалтад 10 албан хаагч

2023 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохин байгуулсан “Ажлын байранд бэлтгэх анхан шатны сургалт”-д Мөрөн сумын улсын бүртгэгч Э.Мөнхсайхан, Галт сумын улсын бүртгэгч Д.Элбэгзаяа нар тус тус хамрагдсан.

Бүгд Найрамдах Солонгос Улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Койка/-ын санхүүжилтээр тус улсын шүүхийн харъяа төрийн албан хаагчдын сургалтын төвөөс 2023-2025 онд хэрэгжүүлэх төслийн хүрээнд “Монгол улсын Улсын бүртгэлийн системийн чадавхыг бэхжүүлэх” эхний шатны сургалтанд Хэлтсийн дарга Б. Мөнгөнзул 2023 оны 9 сарын 10-ны өдрөөс 22-ны өдрийг дуустал хугацаанд хамрагдсан.

2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Мэдээлэл технологийн үндсэний парк зохион байгуулсан Бүх нийтийн мэдээллийн технологийн мэдлэг өнөөгийн байдал, сайжруулах арга зам сургалтад Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн бүртгэгч Б.Цэнд-Аюуш Архивч Д.Пүрэвсүрэн нар

2023 оны 10 дугаар сарын 15-ны өдөр УБЕГ-аас зохион байгуулсан “Бодлогын баримт бичиг боловсруулах” сургалтад хэлтсийн бүх албан хаагчид

2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Нийгмийн даатгалын хэлтсээс зохион байгуулсан “Нийгмийн даатгалын багц хуулийн сургалтад хэлтсийн дарга Б.Мөнгөнзул, Хяналтын улсын байцаагч С.Отгон-Өлзий, Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд ахлах бүртгэгч, Иргэний бүртгэлийн тасгийн дарга бөгөөд ахлах бүртгэгч Б.Өлзийням, Ахлах нягтлан бүртгэгч Б.Мөнхдэлгэр, Мэдээлэл технологийн ажилтан Э.Нарантуяа нар

2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Хөвсгөл аймгийн ЗДТГ Хууль зүйн хэлтсээс зохион байгуулсан Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийн сургалтад хэлтсийн бүх албан хаагчид хамрагдаж шалгалт өгөв.

2023 оны 10 дугаар сарын 24-ны өдөр Цахим хөгжил Харилцаа холбооны яамнаас зохион байгуулсан “Хурдан” үйлчилгээний танхимын сургалтад хэлтсийн бүх албан хаагчид

2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр УБЕГ-аас зохион байгуулсан Дохионы хэлний онлайн сургалтад Мэдээлэл технологийн ажилтан Э.Нарантуяа хамрагдаж бусад албан хаагчдад анхан шатны хичээл заасан

2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдлийг буруулах ажлын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилго бүхий сургалтыг Хэлтсийн дарга Б.Мөнгөнзул, Хяналтын улсын байцаагч С.Отгон-Өлзий нар Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хамтын ажиллагаа, сургалтын хэлтсээс ирүүлсэн хөтөлбөрийн дагуу тус хэлтсийн улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч нар

2023 оны 11 сарын 03-ны өдөр Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар, Хүүхдийн төлөө зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд хэлтсийн дарга Б.Мөнгөнзул, Иргэний тасгийн улсын бүртгэгч П. Даваадулам

2023 оны 11 сарын 07-ны өдөр “Хамтдаа нөлөөлье хөгжье” Гэр бүл хүүхэд хүүхэд залуучуудын хэлтэс болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвөөс зохион байгуулсан сургалтад Иргэний тасгийн улсын бүртгэгч С.Дэлгэрмөрөн

2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр “Угийн бичиг хэрхэн хөтлөх вэ?” сургалтанд Хатгал тосгоны улсын бүртгэгч М.Даваахүү

2023 оны 11 дүгээр сарын 15-ны Нийгмийн даатгалын Ерөнхий газраас зохион байгуулсан Нийгмийн даатгалын шимтгэлийн шинэчилсэн багц хуулийн тухай онлайн сургалтуудад хэлтсийн бүх албан хаагчид тус тус хамрагдсан байна.

10. ДҮГНЭЛТ

Тус хэлтэс нь өдөр тутмын үйл ажиллагаандаа Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандартыг мөрдөн ажиллаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллалаа.

2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг 100 хувь хийж хэрэгжүүлэхээр зорилго тавин ажиллаж гүйцэтгэлийг бүрэн ханган ажилласан байна.

2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас “Цахим гадаад паспорт”-ыг хэрэглээнд нэвтрүүлсэнтэй холбогдуулан гадаад паспорт хурдан шуурхай хэвлэгдэн ирж байгаад иргэд сэтгэл ханамжтай байна. Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоны хэмжээнд 16 нас ба түүнээс дээш насны тоон гарын үсэг авах 90464 иргэнээс өнгөрсөн оны тайлант хугацаанд 24372 иргэнд буюу 27%-тай байсан бол 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар нийт 51488 иргэнд тоон гарын үсэг олгож, тоон гарын үсэг олгох ажил 57%-тай явагдаж, гүйцэтгэлийн төлөвлөгөө 100 хувь хэрэгжсэн.

Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийг анхан шатны нэгжээс үзүүлэх ажлын хүрээнд аймгийн төвөөс хол, алслагдсан Тариалан, Цагаан-Уул, Цэцэрлэг, Их-Уул сумдад нэвтрүүлэхээр нийт 12.140.000 төгрөгийн төсвийг сумын ИТХ-р шийдвэрлүүлэн гадаад паспортын бүртгэл хөтлөх тоног төхөөрөмж /зургийн аппарат, гэрэлтүүлэгч иж бүрэн, хөшиг/ болон үйлчилгээний хураамж төлөх гэрэгэ пос төхөөрөмжийг худалдан авсан. Тус сумдын улсын бүртгэгч нарыг хэлтэст дадлага хийлгэж, гадаад паспортын эрхийг хөтлөх эрхийг нээлгэх албан бичгийг УБЕГ-т хүргүүлэн гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг 4 суманд үзүүлэх боломж бүрдэж байна

Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2023 оны 04 дүгээр сарын 03-ний өдрийн А/02 дугаар “Тооллогын комисс томилох тухай” тушаалын дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын баримтад тооллого хийх ажлыг зохион байгуулж архивт цахим санд бүртгэлтэй 3035, татан буугдсан 325 шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 135 нийт 3495 хуулийн этгээдийн хувийн хэргийн эх нотлох баримтыг цахим сантай тулган алдаа зөрчлийг арилгах ажлыг 100% хийж гүйцэтгэсэн.

Тус хэлтсийн Рэнчинлхүмбэ сумын улсын бүртгэгч П.Оргилсайхан нь сумын Засаг даргын тамгын газар болон ИТХ-ын төвлөрсөн орлогоос улсын бүртгэлийн киоск машины 26.800.000 /хорин зургаан сая найман зуун мянган/ төгрөгийг шийдвэрлүүлж, иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээ авах нөхцөл боломжийг улам ойртуулж, шинийг санаачлан ажилласан албан хаагч боллоо.

Тус хэлтсийн барилгын их засварын төсвийг шийдвэрлүүлэхээр Хууль зүйн сайд Х.Нямбаатарт албан бичиг хүргүүлснээр засварын төсөв болох 478.000.000 /дөрвөн зуун далан найман сая/ төгрөгийг шийдвэрлүүлэн ажиллалаа. Тус хэлтсийн барилгын их засварын ажлыг хийж гүйцэтгэх байгууллагын тендерийн үйл ажиллагаа Улсын бүртгэлийн ерөнхий газарт зарлагдан “Өгөөмөр Уул” ХХК шалгарч барилгын их засварын ажлыг 2023 оны 06 дугаар сарын 18-ны өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн хооронд гүйцэтгэж, тус хэлтэст хүлээлгэж өгсөн бөгөөд хэлтсийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа бүрэн хангагдсан.

Тосонцэнгэл сумын Засаг даргын тамгын газарт хүсэлт хүргүүлэн хүнсний ногоо тариалах зориулалт бүхий 1 га талбайг шийдвэрлүүлэн авч, албан хаагчдын хуримтлалын мөнгөнөөс 1.200.000 төгрөгний төмс бусад ногоог худалдан авч хүнсний ногоо тариалах ажлыг эхлүүлж 4 тонн төмсийг хураан авсан. Ингэснээр хэлтсийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, өөрсдийн санхүүгийн эх үүсвэртэй болох нөхцөл боломжийг бүрдүүллээ.

Дээрх бүрдүүлсэн санхүүгийн эх үүсвэрээсээ “Эрхэм төрийн алба” хэмээх байгууллагын сүлд дууг бүтээн дүрсжүүлээ. Уг дууны үгийг “Ханх сумын улсын бүртгэгч Р.Нэргүй бичиж, аяыг Б. Хангай зохиосон ба дуучин И.Наранзаяагаар дуулуулсан.

Мөн манай хамт олноос гаргасан шинэ, шинэлэг санаачлагаар “Бүртгэлхүү, Бүртгэлмаа” нэртэй контентыг эхлүүлсэн бөгөөд эхний контентыг “Тоон гарын үсэг” сэдвээр бүтээж цахим хуудсанд байршуулаад байна. Энэхүү контент нь бүртгэл тус бүрээр цаашид үргэлжлэх бөгөөд шинэ контентыг тухай бүр цахим хуудаснаа байршуулан бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлан ажиллаж байгаа ба уг ажил нь 2024 онд үргэлжлэн хийгдэх юм.

Тус хэлтэс нь үйл ажиллагаандаа “Хөвсгөлийн Хөгжил дэвшилд” төрийн бус байгууллагаар 2023 оны 11 дүгээр сард 44 албан хаагч, 51 иргэн, Цагдаагийн газар, ШШГГ, Шүүхийн байгууллага болон, орчны ажиглалт гэсэн 4 үндсэн төрлөөр хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, үнэлгээний тайланг хүлээн авлаа.

Үнэлгээгээр тус хэлтсийн давуу тал:

- Иргэдэд үйлчлэх цахим үйлчилгээг нэмэгдүүлж цаг завьг хэмнэсэн иргэдэд цахим машиныг ашиглах зааврыг байршуулсан
- Албан хаагчид ажилдаа идэвх санаачлагатай иргэдэд үйлчилгээ үзүүлэхдээ эерэг хандлагатай байсан
- Иргэд бүртгэлийн үйлчилгээ авахад бүрдүүлэх материалын хөтөч дэвтэр ойлгомжтой байсан.

Сул тал:

- Хэлтсийн албан хаагчдын ахлах нягтлан бодогч, мэдээлэл технологийн ажилтан нарын тоног төхөөрөмж шинэчлэх шаардлагатай
- Төрийн албан хаагчтай иргэд зүй бусаар харьцах, дайрч доромжлох, үйлдэл гаргахгүй байхаас сэргийлэн хууль эрх зүйн санамж байршуулах.
- Орон нутгийн албан хаагчдад томилолтын зардал төсөвт суугаагүй зэрэг болно.

Дээрх үнэлгээнээс үзэхэд тус хэлтсийн зүгээс цаашид иргэдэд чиглэсэн соён гэгээрүүлэх болон Улсын бүртгэлийн нэр хүндийг өргөх ажлыг зохион байгуулах мөн хэлтэст ажиллаж буй залуу боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллах нийгмийн баталгааг хангах тал дээр илүү анхаарч ажиллах нь зүйтэй гэж дүгнэж байна.

Цаашид хөндлөнгийн үнэлгээг жил бүр хийлгэх нь ололт амжилт, алдаа дутагдалдаа дүгнэлт хийн, төр иргэд хоорондын харилцаа уялдаа холбоог сайжруулахад чухал ач холбогдолтой юм.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АЖИЛТАН

Э.НАРАНТУЯА

ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.МӨНГӨНЗУЛ